



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 17-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2023 оны 10 дугаар сарын 17-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 - 3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4 - 34

- 1. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/* 4 - 34

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 10 дугаар сарын 17-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 17 минутад Төрийн ордны “Жанжсин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: С.Бямбацогт, Б.Дэлгэрсайхан, Л.Мөнхбаатар, Ц.Мөнх-Оргил, Н.Учрал;
Чөлөөтэй: Б.Энх-Амгалан.

Нэг.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Улсын ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх Д.Мөнх-Эрдэнэ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга О.Амарсанаа, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга О.Мөнхбаатар, Эрүүгийн хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах, боловсронгуй болгох чиг үүрэг бүхий Байнгын ажлын хэсгийн гишүүн Б.Гантуяа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Ш.Цолмон, шинжээч Т.Нарантунгалаг, мэргэжилтэн Ц.Лхагвацэнд, Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга Л.Нямдаваа, Цагдаагийн ерөнхий газрын Зөрчлийн хэрэг бүртгэлт, мэргэжил арга зүйн хэлтсийн дарга Б.Уртнасан, Тээврийн цагдаагийн албаны Зөрчил шалган шийдвэрлэх хэлтсийн дарга Ц.Чинзориг, Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал С.Гантулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, мөн газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Г.Золжаргал, Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Ш.Адъяаа, Ц.Сэргэлэн, Ш.Раднаасэд, Ж.Сүхбаатар, Ц.Мөнхцэцэг, Д.Ганбат, Д.Цогтбаатар нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар үг хэлэв.

Д.Цогтбаатар: Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 43 минут үргэлжилж, 18 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр 17 цаг 00 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 10 дугаар сарын 17-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордны “Жанжсин Д.Сүхбаатар”
танхим
15 цаг 17 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн мэндийг эрбье.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. /алх цохив/

Миний анхны хурал даргалж байгаа хуралдаан учраас алдаа, эндэгдэл гарвал та нар маань уучилж хүлээж аваарай.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Хуралдааны ирц одоогоор 55.6 хувь байна.

Гишүүдийн нэрсийг дуудаад явчихъя. Ш.Адъяаа гишүүн ирсэн байна, Н.Алтанхуяг гишүүн ирсэн байна, Э.Бат-Амгалан гишүүн ирсэн байна. Л.Мөнхбаатар гишүүн, Ц.Мөнх-Оргил гишүүн гадаадад томилолттой явж байгаа. Ц.Мөнхцэцэг гишүүн ирсэн байна, Б.Пүрэвдорж гишүүн ирсэн байна, Ш.Раднаасэд гишүүн ирсэн байна, Ц.Сандаг-Очир гишүүн ирсэн байна, Ж.Сүхбаатар гишүүн ирсэн байна, Б.Энхбаяр гишүүн ирсэн байна.

Ирц бүрдсэн тул ингээд хуралдаанаа эхлүүлээд явж байна. Ирц хангагдсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Байнгын хорооны энэ удаагийн хуралдаанаар Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх болно. Энэ бол хэлэлцэх эсэх асуудал бид хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу? Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байхгүй тул хэлэлцэх асуудлаа баталлаа. /алх цохив/

Хэлэлцэх асуудалдаа орёё.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаарх хэлэлцүүлгийг явуулъя.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Баттөмөрийн Энхбаяр танилцуулна.

Б.Энхбаяр гишүүнд микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Байнгын хорооны эрхэм дарга, гишүүдийнхээ амгаланг айлтгая.

Монгол Улсын Засгийн газраас нэн яаралтай горимоор Монгол Улсын Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт

оруулах тухай хуулийн төслийг өргөн барилаа.

Эрүүгийн хуулийн гол өөрчлөлтийн агуулгыг Та бүхэнд танилцуулъя.

Юуны урьд бага насны хүүхдийг алах, бага насны хүүхдийг хүчиндэх, бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн бэлгийн мөлжлөг, хүүхдийн эсрэг хүн худалдаалах гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг 30 жил ба бүх насаар хорих ялтай болж байгаа тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа тооцохгүй байх өөрчлөлтийг оруулна.

Хүнийг алах гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн, бага насны хүүхдийг алах, бага насны хүүхдийг хүчиндэх, бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн бэлгийн мөлжлөг, хүүхдийн эсрэг, хүн худалдаалах гэсэн гэмт хэргүүдэд өршөөл үзүүлэхгүй.

Мөн сая дурдсан хүүхдийн эсрэг гэмт хэргээс гадна аливаа төрлийн авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн хорих ял эдэлж байгаа этгээд, мөн хүнийг алах гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнээр хорих ял эдэлж байгаа этгээдийн тухайтад хорих ялаас хугацаанаас нь өмнө суллахгүй гэсэн ийм саналыг дэвшүүлж байна.

Бага насны хүүхдийг алах, бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт оногдуулах ялын дээд хэмжээ 20 жил байгааг 25 жил болгоё гэсэн өөрчлөлтийг санал болгож байгаа.

Яагаад энэ төрлийн гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгах шаардлага байна вэ гэхээр 2002-2015 оны Эрүүгийн хуульд бага насны хүүхдийн эсрэг үйлдэгдсэн бэлгийн эсрэг ийм гэмт хэрэгт оногдуулж байгаа ялын бодлого

2015 оны хуулиар багассан байна гэж нэгдүгээрт үзсэн.

2018-2022 оны сүүлийн 5 жилийн байдлаар хүчиндэх гэмт хэрэг үйлдсэний улмаас хохирсон хохирогчдын 62.7 хувь нь хүүхдүүд байсан байна гэдэг ийм харамсалтай дүн мэдээ гарсан.

Шүүхээс энэ төрлийн ял шийтгэлийг Эрүүгийн хуулийг хэрэглээд ер нь ямар ял шийтгэл ногдуулж байгаа вэ гэдэг энэ тооцоо судалгааг авч үзсэн.

Ингэхэд 2021 онд шүүхээс нийтдээ 54 орчим хувь нь бага насны хүүхдийн эсрэг үйлдэгдсэн хүчингийн гэмт хэрэгт 10-аас 15 жилийн хорих ял шийтгэгдсэн байна гэдэг ийм дүн гарсан.

Өөрөөр хэлбэл манай шүүхийн ялын бодлогыг улам чангатгах шаардлага байгааг харуулсан.

Энэ төрлийн гэмт хэргүүдийг үйлдсэн шүүхээс ял оногдуулсан ялтны 22.7 хувь буюу 98 нь урьд нь ял шийтгүүлж байсан этгээдүүд байна гэдэг тооцоо гарсан байгаа.

Хорих ялаас хугацаанаас өмнө суллахгүй байх. Сая хэлсэнчлэн хэргүүд хүнийг алах гэмт хэргийг хүндрүүлэх бүрэлдэхүүн, бага насны хүүхдийг алах, бага насны хүүхдийг хүчиндэх, бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн бэлгийн мөлжлөг, хүүхдийн эсрэг, хүн худалдаалах гэсэн энэ гэмт хэргүүдэд Улсын Их Хурлаас цаашид өршөөл үзүүлэхгүй гэдэг саналыг дэвшүүлж байгаа.

Нийтдээ хүнийг алах, хүчиндэх, авлига, албан тушаалын гэмт хэрэгт ял эдэлж байсан хүмүүсээс сүүлийн 10 жилийн байдлаар 3879 этгээдийг сулласан байна гэдэг дүн гарсан. Үүнээс

6 хүн нь хүчиндэх гэмт хэргийг давтаж үйлдэж хорих ялаар шийтгүүлсэн байна. 3873 нь дахин гэмт хэрэг үйлдээгүй байна гэдэг байдалтай байна.

Хорих ялаас хугацаанаас өмнө суллагдсан 3879 хүний 52.9 хувь нь хүнийг алах гэмт хэрэг үйлдсэн, 45.4 хувь нь хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн, 13.7 хувь нь бага насны хүүхдийн хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн, 1.6 хувь нь авлига албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн этгээдүүд байсан.

Энэ хорих ялаас хугацаанаас өмнө өршөөл, уучлал үзүүлэгдсэн байдал дээр авч үзэхэд 77.5 хувь нь хугацаанаас өмнө шүүгчийн захирамжаар суллагдсан, 12.2 хувь нь хорих ялын хугацаа дуусаж суллагдсан, 5.6 хувь нь Эрүүгийн хуулийн тэгшитгэлд хамрагдсан, 2.6 хувь нь өвчний учир ялаас чөлөөлөгдсөн, 0.9 хувь нь өршөөл үзүүлэгдсэн, 0.6 хувь нь Улсын дээд шүүхийн тогтоолоор, 0.2 хувь нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар суллагдсан байсан.

Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт Монгол Улсын Ерөнхийлөгчөөс уучлал үзүүлж байгаагүй байна.

Бага насны хүүхдийн Эрүүгийн хуульд байгаа насны хязгаарыг 14-өөс 16 болгон нэмэгдүүлэх өөрчлөлтийг Засгийн газраас санаачилж байгаа.

Үүнтэй холбоотойгоор бага насны хүүхдийг алах, хүчиндэх, бага насны хүүхдийн эсрэг бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, бага насны хүүхдийн эсрэг бэлгийн мөлжлөг, бага насны хүүхдийг аюултай байдалд орхих, тусламж үзүүлэхгүй байх, бага насны хүүхдийг оролцуулж садар самууныг сурталчлах, хүн хулгайлах, хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах, хүний эрүүл

мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах гэсэн эдгээр гэмт хэргүүдийн хохирогч 14-өөс 16 насны хүүхдүүдэд ял шийтгэж байсан ялын бодлогыг чангалж байгаа юм.

Өөрөөр хэлбэл 14-өөс 16 болгосноор нийтдээ 14-өөс 16 насны хүүхдийн эсрэг үйлдэгдэж байсан сая хэлсэн 10 орчим эрүүгийн гэмт хэргийн ялын бодлогууд чангарч байгаа юм гэдгийг Та бүхэнд хэлье.

Энэ зүйл болгон дээр 2015 оны хуулиар ямар ял шийтгэж байгаа, хэрхэн ял шийтгэлийн бодлого чангарч байгаа вэ гэдгийг Та бүхэнд слайдаар дэлгэрэнгүй танилцуулсан.

Үүнтэй холбоотойгоор хүчиндэх гэмт хэргийн шинжийг мөн тодорхой болгож байгаа.

Өөрөөр хэлбэл хүчээр бэлгийн харьцаанд орох, бэлгийн харьцааны шинжтэй хүчирхийлсэн үйлдлийг ялгаж байгаа.

Одоо 2015 оны хуулиар энэ хоёр үйлдлийг ялгалгүйгээр ял шийтгэлийн бодлого нь явж байгаа.

Өөрөөр хэлбэл хурьцал үйлдэж төгссөн үйлдэл, яг хурьцал үйлдээгүй бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл гаргасан үйлдэлд ял шийтгэлийн ялгамжтай бодлого бариад, хурьцал үйлдсэн хүчиндэх гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн бодлогыг 1-ээс 5 жил байгааг 2-оос 8 жил болгож, тухайн гэмт этгээдийг тэнсэхгүй байх чиглэлээр ял шийтгэлийн бодлогыг чангатгах саналыг дэвшүүлж байна.

Мөн 16 насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон, гэр бүлийн хамаарал

бүхий 16 насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн гэмт хэрэгт оногдуулах хорих ял 8-аас 15 жил байгааг 12-оос 25 жил болгон нэмэгдүүлж, бүх насаар нь хорих ял ноогдуулахаар ял шийтгэлийн бодлогыг дэвшүүлж байна.

Үүнтэй холбоотойгоор мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах гэмт хэрэгт гэмт хэргийн тусгай субъектүүдэд оногдуулах ял шийтгэлийн бодлогыг чангатгах саналыг дэвшүүлж байгаа.

Өөрөөр хэлбэл тухайн мөрдөн шалгах арга, ажиллагааны нууцыг задруулж байгаа албан хаагч ажилтанд оногдуулах ял шийтгэл нэг сараас нэг жил байсныг 6 сараас 3 жил болгоод шүүгч, прокурор, хууль сахиулагч, өмгөөлөгч, албан үүргийн дагуу олж мэдсэн албан хаагч мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулж нууцалсан гэрчийг илчилсэн үйлдэлд оногдуулах торгох ялыг хасаад, 6 сараас 3 жил хорих ял ноогдуулж байгааг 1-ээс 5 жил болгон нэмэгдүүлэх саналыг дэвшүүлж байгаа.

Мөн согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох үйлдэлдээ эвлэрэхгүй байя гэдэг бодлогыг дэвшүүлж байгаа.

Одоогоор согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон, мөн согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож бусдын би эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан үйлдлийг зөрчлийн хуулиар торгож шийтгэж байгаа. Энэ үйлдлийг гэмт хэрэгт тооцож ял шийтгэх бодлогыг дэвшүүлж байна.

Тээврийн хэрэгсэл жолоодох, эрх хасах ялыг бүхэлд нь нэмэгдүүлээд бүх насаар нь хасах хүртэл тээврийн хэрэгсэл жолоодохыг нь хасъя гэдэг ийм саналыг дэвшүүлж байна.

Яг ямар ял шийдэх гэж байгаа юм бэ гэхээр тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нь 1-ээс 3 жил хүртэл хугацаагаар хасаад, 450-аас 2.7 мянган нэгжээр торгоно. 450 мянгаас 2.7 сая төгрөгөөр торгох, эсвэл 240-өөс 720 цаг нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл 6 сараас 1 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 6 сараас 1 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх бодлогыг дэвшүүлж байна.

Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөний улмаас хүний эрүүл мэндэд хүндэтгэр хохирол учруулах юм бол 3-аас 5 жил, хүнд хохирол учруулбал 5-аас 8 жил, согтуурсан, мансуурсан үедээ хүний амь нас хохироосон бол бүх насаар тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасах нэмэгдэл ялыг ногдуулах ийм бодлогыг дэвшүүлж байна.

Яагаад энэ бодлогыг гэмт хэрэгт тооцож ял шийтгэлийн бодлого шаардлага байна вэ гэхээр 2017-2023 онд согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон нийт 252 мянга 838 зөрчил бүртгэгдсэн.

Жилд дунджаар 36 мянга 120 зөрчил гарч байна. Дунджаар нэг жилд согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсоны улмаас 110 хүн амь насаа алдаж байна.

Өнгөрсөн оны 8 сараас энэ оны 8 сарын байдлаар согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил 33 мянга 723 бүртгэгдсэн.

Нэг эерэг мэдээ нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсоны улмаас хүний амь нас хохирсон асуудал хоёр дахин буурсан буюу 50 хүн нэг жилийн хугацаанд амь насаа алдсан байна.

Ер нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон сүүлийн нэг жилийн

тухайтад бас энэ хүний амь нас хохирсон үйлдэл буурч байгаа ийм асуудал дээр бид анализ хийж үзсэн.

Ер нь нийт гэмт хэргийн гаралтад согтуугаар үйлдэгдэж байгаа гэмт хэргийн гаралт 15.8 хувиар сүүлийн нэг жил буурсан байгаа юм.

Энд ямар шалтгаан нөхцөл нөлөөлж байна вэ гэдгийг бид авч үзэх ёстой. Хүний амь нас хохирсон үйлдэл хоёр дахин буурсан байна. Архины борлуулалт буурсан байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад энэ оны байдлаар 1.2 сая литрээр архины борлуулалт буурсан гэдэг ийм байдлыг бид олж авсан байгаа.

Ингээд Та бүхнийг Монгол Улсын Засгийн газраас нэн яаралтай горимоор өргөн барьсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Б.Энхбаяр сайдад баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулья.

Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Улсын ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх Д.Мөнх-Эрдэнэ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга О.Амарсанаа, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга О.Мөнхбаатар, Эрүүгийн хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах, боловсронгуй болгох чиг үүрэг бүхий

Байнгын ажлын хэсгийн гишүүн Б.Гантуяа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч Т.Нарантунгалаг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн Ц.Лхагвацэнд, Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга Л.Нямдаваа, Цагдаагийн ерөнхий газрын Зөрчлийн хэрэг бүртгэлт, мэргэжил арга зүйн хэлтсийн дарга Б.Уртнасан, Тээврийн цагдаагийн албаны Зөрчил шалган шийдвэрлэх хэлтсийн дарга Ц.Чинзориг, Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал, доктор (Ph.D), дэд профессор, цагдаагийн дэд хурандаа С.Гантулга.

Оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцууллаа.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан төсөл санаачлагчаас асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Ц.Мөнхцэцэг гишүүнээр тасалъя.

Н.Алтанхуяг гишүүн асуултаа асууна.

Н.Алтанхуяг: Хуулийн ерөнхий концепцоороо зарим төрлийн гэмт хэргүүдэд үзүүлдэг ялын бодлогыг чангалж байгаа, өршөөл үзүүлдгийг нь болиулж байгаа ерөнхий концепцыг нь би ерөнхийд нь дэмжиж байна.

Надад юун дээр л асуулт байна. Мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах гэмт хэргийн ялын бодлого гэдэг дээр.

Би үүгээр чинь их олон янзаар явж, бүр Ерөнхий сайд байхдаа хүртэл.

Энэ прокурорынхон чинь гоё погонтой хувцсаа өмсөж ирж байгаад л аймаар аймаар юм яриад л мэдээлэл хийдэг байсан л даа.

Тэгээд сүүлийн үед яаж байна. Би мэдэхгүй байна.

Тэгэхээр надад ямар асуулт байгаа вэ гэхээр манай сэтгүүлчид яриад ингээд “хүн” гээд байгаа юм. Би үгэн дээр ярьж байна шүү. Б.Энхбаяр сайд аа. “Хүн” гээд ингээд өргөтгөөд ингэчихээр энэ чинь нэг дампуу юм болдог л доо.

Тэгэхээр би Х.Тэмүүжин сайдын үед, манай Засгийн үед үүнийг яаж хийх гэж оролдож байсан юм гэхээр мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах гэмт хэргийг зөвхөн хууль сахиулагч, прокурор, шүүгч гэсэн гурван этгээдээр хязгаарлаж байсан юм.

Тэгээд үүний дараа нь Д.Дорлигжав гарч ирээд тэгээд дампууруулаад. Одоо ингээд хавтгайрсан шинжтэй болчихсон. Энэ яг яаж журамлагдаж байгааг надад нэгдүгээрт хэлж өгөөч.

Хоёрдугаарт нь, нууцлагдвал зохих баримт мэдээлэл. Хамаг юмаа нууна гэж байж болохгүй.

Тэгэхээр энэ дээр нууцлагдвал зохих баримт, мэдээлэл гэдэгт нууцлагдсан гэрч, нууц мөрдөн шалгах ажиллагаа явуулж цуглуулсан нотлох баримт гэж хумьчихсан байсан байхгүй юу.

Одоо ерөөсөө энэ маш буруу болсон.

Би дахин хэлье. Энэ төсвийн хөрөнгөөр хийсэн юмаа хүртэл нууц болгоод явдаг байхгүй юу. Монголд

ерөөсөө нууцгүй юмгүй болчихсон байхгүй юу. Тэгээд тэр сэтгүүлчид жаахан дутуу ойлгосон уу. Бас ингээд эмзэглээд байгаа нь би нэг их буруу гэхгүй байгаа юм. Сайхан тайлбарлаад учир начраа олоод.

Тэгээд энэ Х.Тэмүүжин сайдын үед тэр үеийн Хууль зүйн яамны оруулж ирж байсан тэр үеийн Засгийн газрын бодлогыг одоо та нар ингэж шигтгэж байна уу, эсвэл хэнийх ч хамаагүй, тэгээд субъект нь хэн ч хамаагүй, тэр хэрэг нь ерөөсөө л бүгдээрээ нууц гэдэг энэ агуулгаараа орж ирж байна уу?

Надад яг ийм хоёр тодорхой асуултад хариулт өгөөч ээ гэж байгаа юм. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Хэн хариулах вэ? Б.Энхбаяр сайд.

Б.Энхбаяр: Энэ мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах гэмт хэрэг бол манай улсын эрүүгийн хууль тогтоомжид 1926 оны үед анх хуульчлагдсан.

1940, 1960, 1986, 2002, 2015 гэсэн бүх эрүүгийн хууль тогтоомжид энэ үйлдлийг гэмт хэрэгт тооцсоор ирсэн байдаг. Хамгийн анхны 1926 онд энэ үйлдэлд 100-аас 600 төгрөгөөр торгох ял ногдуулдаг байсан юм байна.

Тэгэхээр 100 жилийн өмнөх 100 төгрөг гэдэг бол одоо та бүхэн ямар айхтар хатуу чанга ял шийтгэдэг байсан бэ гэдгийг харж болно.

2013 онд таны Засгийн газар анх Гэмт хэргийн тухай хууль Улсын Их Хуралд өргөн барих үед энэ үйлдлийг зөвхөн тусгай субьектэд нэр оноосон байдлаар буюу шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөн байцаагч гэсэн

хүрээнд хамааруулж өргөн барьж байсан юм байна лээ.

Ингээд Д.Дорлигжав Хууль зүйн сайд болоод татаад буцааж өргөн барихдаа үүнийг тухайн мөрдөн шалгах ажиллагааны нууцыг олж авч мэдсэн хүн гэдэг агуулгаар Улсын Их Хуралд өргөн барьж тухайн зүйл, заалтад ямарваа нэгэн өөрчлөлт орохгүйгээр батлагдсан байдаг.

2017 онд Эрүүгийн хуульд өөрчлөлт ороход тухайн зүйл, заалтын шинжид өөрчлөлт оруулахгүй, зөвхөн ял шийтгэлийн бодлого дээр хугацааг нь нэмсэн ийм өөрчлөлт 2017 онд орж байжээ.

Энэ гэмт хэргийн гол онцлог нь яагаад “хүн” гэдэг агуулгаар өргөтгөсөн бэ гэхээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ганцхан мөрдөн байцаагч, шүүх, прокурор, өмгөөлөгч гэсэн ийм 4 этгээдийн хүрээнд явагддаггүй.

Тухайн хэрэг шинжлэх ажиллагаанд хэлмэрч, орчуулагч, шинжээч, хөндлөнгийн гэрч, эрүүгийн хэрэг дэх иргэний хариуцагч, иргэний нэхэмжлэгч гэсэн этгээдүүд мөн мөрдөн шалгах үйл ажиллагааны хавтаст хэрэгтэй танилцдаг. Мөн нууцын баталгаа гаргасан байдаг.

Тэгэхээр эдгээр хүмүүсийг хамруулахын тулд энэ хүрээнд ойлгож энэхүү нэр томъёог хэрэглэж явж байжээ.

Яг энэ агуулгаараа буюу 2015 оны хууль, саяын хэлсэн олж мэдсэн хүн гэдгийг зөвхөн процесс ажиллагааны саяын хэлсэн хүрээний оролцогчдын хүрээнд ойлгож хууль хэрэглээнд хэрэглэж явж ирсэн байна.

Монгол Улсын Дээд шүүхийн тайлбарт ч гэсэн энэ гэмт хэргийн субъект нь зөвхөн саяын хэлсэн хүрээнд ойлгогдоно гэдгийг тайлбарлаж хэрэглэж ирсэн байна.

Өөрөөр хэлбэл мөрдөн шалгах ажиллагааны мэдээллийг олж мэдсэн, бусдад задруулсан бусад иргэн, хүмүүст энэ зүйл, ангиар ял шийтгэж байгаагүй гэсэн үг.

Тэр ч утгаараа би бас өчигдөр хэвлэлийн бага хурал хийсэн. Энэ бол бусад иргэд, жирийн иргэд, тэр дотроо хэвлэл мэдээллийн байгууллагад хамаагүй.

2015 оны Эрүүгийн хууль 2017 оны 7 сарын 01-нээс хүчин төгөлдөр үйлчилж ирсэн. Үйлчилж эхэлснээс хойш шийтгэгдсэн нэг ч сэтгүүлч Монгол Улсад байхгүй гэдгийг хэлье.

Мөрдөн шалгах ажиллагааны нууц гэдэг нь өөрөө онцлог. Энэ бол үйл баримт буюу тухайн хавтаст хэрэгт байгаа үйл баримтын тухай мэдээлэгдэхгүй байх асуудал биш. Тухайн хэргийг илрүүлэх зорилгоор, гэрч хохирогчийг хамгаалах зорилгоор нууцалж байгаа арга ажиллагааны тактикийн холбоотой мэдээллийг хэлж байгаа юм.

Арга ажиллагааны тактик. Энэ бол нууц байна. Хэзээ барих гэж байгаа юм, ямар үзлэг, нэгжлэгүүд хийгдсэн юм, юу хураагдаж авсан юм гэдэг энэ асуудлыг жишээлбэл хөндлөнгийн гэрч танилцдаг. Энэ этгээд залруулж болохгүй гэдэг нууцын баталгаа бас.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Нэмж асууя.

Н.Алтанхуяг: Хариулт чинь дууссангүй шиг л боллоо.

Би зүгээр ингээд байгаа юм.
Б.Энхбаяр сайд аа.

Б.Энхбаяр: Энэ хууль сахиулагч, прокурор, шүүгч гэсэн гурван этгээдээр хязгаарласныг та ийм ийм зүйл үүний цаана ойлгоно гээд.

Тэгвэл тэр яаж томъёолдог юм. Томъёолмоор байна. Энэ өөр амьтанд нялзаагаагүй гэдгийг томъёолмоор байна.

Дээд шүүхийн тайлбараар бас тэгчихэж болох юм уу. Хэдүүлээ энэ хууль дээрээ нялзаамааргүй л байхаар бичигдмээр байна гэж би хүсээд байгаа юм.

Нөгөөдөх нь бол. Та одоо ийм санаа хэлээд байна шүү дээ.

Тэр мөрдөн байцаах. Одоо тэр мөрдөн байцаалтын нууц гэхээр ерөөсөө бүх юмыг нууц гээд байдаг байхгүй юу. Би одоо жишээлбэл. Та нарт амьдрал дээр гарсан жишээ хэлж өгье.

Би нэг нөхрийг самбар дээрээ шүүмжилсэн чинь намайг шүүхэд өгөөд. Тэгээд би шүүх дээр очоод эхний энэ хавтас нь ингээд нууц биш явж байсан байхгүй юу. Тэгж байсан тэр нөхөр чинь тагнуулаас нэг бичиг аваад хүрээд ирсэн чинь хоёр дахь хавтас нь нууц болоод. Хоёр дахь.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Санал дээр хэлээд явчих. Б.Энхбаяр сайд.

Б.Энхбаяр: Н.Алтанхуяг гишүүн бол сүүлийн 30 жилд хуулийн хонгилоор хамгийн удаан чирэгдсэн Монгол Улсын Ерөнхий сайд.

Н.Алтанхуяг Ерөнхий сайдыг огцруулах зорилгоор хуулийн

байгууллагынхан огцруулах эсэх асуудлыг Улсын Их Хурал дээр шийдэхийн өмнө нь хэвлэлийн бага хурал хийж Н.Алтанхуяг, Н.Алтанхуягийн хүүхдүүдийг шалгаж байгаа хэрэгтэн мэтээр цоллосон.

Энэ бол одоо Монгол Улсын Засгийн газрыг хүртэл огцруулах, нөлөөлөх хэмжээнд оролцож байгаа ийм зүйл анги.

Тийм учраас би энэ ял шийтгэлийн бодлогыг чангаруулах ёстой гэж үздэг. Хонгилыг нураах ёстой. Хонгилыг хуулиар л нураана. Ийм байж таарахгүй.

Н.Алтанхуягийг огцруулж байгаад Дубайн гэрээ хийсэн. Н.Алтанхуягийг огцруулж байгаад 49-ийг хулгайлсан. Одоо энэ.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Ш.Адьяа гишүүн асуултаа асууя.

Ш.Адьяа: Өнөөдөр Монгол Улсын Засгийн газраас Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг яаравчилсан горимоор оруулж ирж өнөөдөр Хууль зүйн байнгын хороогоор хэлэлцэж байна.

Ялангуяа хүүхдийн эсрэг гэмт хэргийг яаралтай горимоор оруулж ирье гэж миний бие Улсын Их Хурлын гишүүний хувьд шаардлага тавьсан. Энэ хүсэлтийг Засгийн газар хүлээж авсан гэж ойлгож байгаа.

Хүүхдийн тухай асуудлыг эрүүгийн нөхцөл байдалтай уялдуулж өнөөдөр ингэж яаралтай горимоор оруулж ирэх нь цаг үе нь нийцсэн асуудал гэж ойлгож үүнийг дэмжиж байгаа.

Үүнтэй давхцаад авто тээвэр, энэ мөрдөн шалгах гээд энэ хуулийн төслүүдийг зайлшгүй яаралтай горимоор оруулж ирэх ямар шаардлага байсан юм гэдэг талаар нэг хариулт авмаар байна.

Дээр нь, Эрүүгийн хууль гэдэг нийгмийн том харилцааг зохицуулдаг, хүнтэй холбоотой, хүний эрхтэй холбоотой, хүний амьдралтай холбоотой асуудал учраас нэр томъёоны хүрээнд ч гэсэн үүнийг үсэг нэг бүрээр бид ярилцах ёстой.

Энэ тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг бүх насаар нь хасна гэдэг чинь ямар асуудал вэ? Бүх насаараа хасна гэдэг юм чинь ингээд юм бүхэн дээр гараад байх нь зөв үү, буруу юу гэдэг дээр нэг хариулт авъя.

Тээврийн хэрэгслийг согтуурсан, мансуурсан үедээ жолоодох тухай ярьсан байна.

Энэ мансуурна гэдэг чинь хар тамхитай холбоотой асуудал. Жолоодох, согтуурах асуудал хар тамхи, мансуурах хоёрыг нь хольж хутгаж нэр томъёоны хувьд ингэж оруулж ирж байх нь зөв шийдэл үү?

Аль эсвэл энэ хар тамхи татдаг, мансуурдаг хүмүүсийг мөн энэ хуулиар давхар шийтгэх асуудал энд яригдах юм уу гэдэг асуудлыг хөндөж тавьж байна.

Мөрдөн шалгах ажиллагааны тухай хуулийг, нууцыг задруулахтай холбоотой асуудлыг зайлшгүй ярих ёстой. Энэ бол одоо ярих ёстой зайлшгүй асуудал.

Сүүлийн жилүүдэд мөрдөн шалгах ажиллагаа хүнийг нэр төрийг гутаан доромжлох, гүтгэхийг ярихаа больё.

Улс төрийн зорилгоор хэвлэл мэдээлэлтэй хамтарч хэн нэгнээс өшөө авах ийм хэрэгсэл болгож байгаа шүү дээ. Үүнийг нуух юм байхгүй. Тэгээд энэ дотор хэн задруулдаг юм гэхээр улс төрчидтэй холбоотой мөрдөн шалгах байгууллага тэрийг задруулдаг гэдэг нь нууц биш байна. Энэ бол нууц биш.

Тийм учраас энд би нэг зүйлийг Б.Энхбаяр сайдаас асууя.

Энэ Прокурорын дэргэдэх мөрдөн шалгах байгууллага гэж байсан. Үүнийг татан буулгасан. Үүнтэй та ер нь санал нэг байдаг уу?

Өнөөдөр энэ мөрдөн шалгах байгууллагыг улсын нууц, гэмт хэргийн нууц задруулсан улмаас хэчнээн хүн өнөөдөр ял шийтгэл, хариуцлага хүлээсэн бэ?

Энэ шүүхээр хэдэн хүн шийтгэгдсэн бэ? Ямар судалгаа байна гэдэг талаар нэг тоо баримт байна уу?

Ер нь өнөөдөр мөрдөн шалгах байгууллагын, ялангуяа хэвлэл мэдээлэлтэй хамтарч зохион байгуулдаг, энэ гэмт хэргийг мэдээлдэг, аливаа сенсац дэгдээдэг асуудал чинь ингээд үргэлжлэх нь нийгэмд зөв юм уу, буруу юм уу гэдэг талаар нэг хариулт авъя.

Тэгээд би сүүлд нь нэмж асуух асуулт байна.

Д.Цогтбаатар: Б.Энхбаяр сайдын микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Энэ ял шийтгэлийн бодлогыг чангаруулах дээр сэтгэлийн хөөрлөөр ч гэдэг юм уу, нийгмийн шууд шаардлагаар ганцхан хандаагүй гэдгийг юуны урьд хэлье.

Сая та бүхэн танилцуулсан судалгаанаас харсан байх.

Миний хувьд ч гэсэн арай ч ийм байна гэж бодоогүй. Яг судалгаа хийгээд, хуулийн төслийг өргөн барих хүрээнд өргөн хүрээтэй судалгаа хийхэд харамсалтай дүн гарсан.

Хүчиндэх гэмт хэргийн хохирогч нь 3 хүний 2 нь хүүхэд гэдэг аягүй аймшигтай тийм дүр зураг.

Тийм учраас яалт ч үгүй энэ төрлийн ялын бодлогыг чангатгахаас өөр арга алга.

Яагаад. Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийг дахин давтан үйлдэж байгаа этгээд бол эрүүл хүн биш. Энэ бол өвчтэй хүн. Сэтгэцийн хувьд эрүүл хүнээс хэзээ ч ийм үйлдэл гарахгүй.

Тийм учраас энэ бол өвчин учраас дахин давтагдах өндөр эрсдэлтэй. Өндөр. Тэр дотроо энэ төрлийн гэмт хэрэг гэр бүлийн ойрын хүрээнд үйлдэгдэж байгаа нь бүр сэтгэл түгшээж байгаа.

Тийм учраас ял шийтгэлийн бодлогыг чангатгах асуудлыг яаралтайгаар оруулж ирсэн.

Өнгөрсөн долоо хоногт энэ асуудал хэвлэл, мэдээллийн хэрэгслээр маш их өндөр авахад энэ төрлийн гэмт хэрэг яг долоо хоног огцом өссөн. Энэ бол яг өвчтэй хүмүүсийн тухайд сэдэл өгч байна гэсэн үг.

Долоо хоногийн хугацаанд энэ төрлийн мэдээлэл харьцангуй хэвлэл, мэдээллийн хэрэгслээр бага байлаа. Би өнөөдөр мэдээлэл авч үзэхэд өнгөрсөн долоо хоногийнхоос 60 хувиар хүчиндэх гэмт хэрэг буурсан байна.

Тэгэхээр энэ юуг хэлээд байна вэ гэхээр иргэд олон нийтэд ч гэсэн энэ асуудлыг ер нь хэвлэл, мэдээллийн хэрэгслээр шуугидаг, сенсацлуулдаг. Ийм байж болдог юм гэдгийг. Ер нь түгээнэ гэхээсээ л ер нь түдгэлзмээр юм билээ. Үүнийг би хүн бүхэнд хандаж хүсэх байна.

Тэр мансуурсан гэдэг юу хэлээд байна вэ гэхээр хар тамхи биш ээ. Тэр янз бүрийн байдлаар тэгээд цавуу үнэртдэг, янз бүрийн мансуурчихсан хүмүүсийг хэлж байгаа юм. Өөр бусад төрлийн. Гутлын тос үнэртээд мансуурдаг, янз бүрийн эм хэрэглэдэг. Тэрийг хэлж байгаа шүү.

Хар тамхитай холбоотой ял шийтгэлийн бодлоготой холбоотой асуудлыг ирэх сард би Хар тамхины эсрэг багц хуулийн төсөл санаачилна гэсэн бодолтой байгаа. Ажлын хэсгээ байгуулчихсан ажиллаж байна.

Мөрдөн шалгах ажиллагааны нууц. Ер нь прокурорын мөрдөнтэй холбоотой асуудлыг би ажлаа авсныхаа маргааш цагдаагийн байгууллага дээр очихдоо хэлчихсэн. Хугацаатай үүрэг хууль сахиулагчдаа өгчихсөн байгаа.

Мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулдаг үйлдлийг нэн даруй таслан зогсоохыг би үүрэг болгосон. Дахиж асуудал яригдах юм бол прокурорын мөрдөнг байгуулах шаардлага үүсэхийг үгүйсгэхгүй гэдэг байр сууриа би илэрхийлчихсэн байгаа.

Өөрөөр хэлбэл өөрөө өөртэйгөө асуудал ярьж чаддаггүй юм бол хөндлөнгийн хараат бус мөрдөн шалгах алба байгуулж байж энэ асуудал дээр цэг тавигдаж таарна гэдэг нь туйлын ойлгомжтой байгаа.

Энэ бол тогтчихсон сүлжээ байна. Тогтчихсон сүлжээ байна. Үүгээр дамжуулж онц их хэмжээний шантааж, хахууль авч байгаа үйлдлүүд бас байна.

Тийм учраас удахгүй асуудлууд улам тодорхой болчих байх гэж хэлье дээ.

Д.Цогтбаатар: Нэмж 1 минут Ш.Адъяа гишүүнд.

Ш.Адъяа: Б.Энхбаяр сайдын ялын бодлоготой холбоотой асуудлыг дэмжиж байгаа юм.

Тэгэхдээ энд тэр мансуурах гэдэг юмаа энэ гутлын тос үнэрлэнэ ч гэдэг юм уу, цавуу үнэрлэнэ гэдэг энэ асуудлаа тэр архи согтууруулах ундаанаас өөр байдлаар оруулахгүй бол энэ чинь өөр ойлголт явагдаад байна гэдгийг би зориуд энд протоколд тэмдэглүүлж хэлье.

Тэгвэл энэ цавуу, тэр гутлын тос гэдэг чинь яг юу юм гэдгийг Эрүүгийн хуулиар шийдэх юм уу, шийдэхгүй юм уу гэдэг асуудлыг энд оруулж өгөхгүй бол энэ согтууруулах ундаатай, тээврийн хэрэгсэл жолоодохдоо хутгаж ойлгож болохгүй гэж бодож байна.

Дээр нь мөрдөн шалгах, нууц задруулах холбоотой энэ асуудал бол мөрдөн шалгах байгууллагын хүмүүстэй холбоотой асуудал.

Дээр нь энэ улс төрчидтэй бас холбоотой асуудал шүү. Үүнийг тодорхой олж өгөх.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Ц.Сэргэлэн гишүүн асуултаа асууя.

Ц.Сэргэлэн: Баярлалаа. Би хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт

оногдуулах ялын бодлогыг чангатгах энэ хуулийн төслийг дэмжиж байна.

12.1 дүгээр зүйл дээр хүчиндэх гэмт хэрэг гээд, тэгээд энэ 1, 2, 3, 4 ялын бодлогыг чангатгах тухай асуудал танилцуулагдлаа. Ялангуяа энэ дээр энэ 4 дэх буюу гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүний ялыг чангатгана гээд.

Тэгээд 16 насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон гэр бүлийн хамаарал бүхий 16 насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн гэмт хэрэгт оногдуулах хорих ялыг гэж байгаа юм. 8-аас 15 байсныг. Одоо бол хууль дээр 8-аас 15 байгаа юм байна л даа. Үүнийг 12-оос 25 болгон нэмэгдүүлж гээд, эсхүл бүх насаар хорих ял оногдуулна гэж ингэж томъёолсон байна.

Тэгэхээр би үүнийг юу гэж харж байна вэ гэхээр энэ төрлийн гэмт хэрэгт 12 жилийн ял оногдуулчхаж болох юм байна. 25 жилийн хорих ял ч оногдуулж болох юм байна. Бүр бүх насаар нь ч хорьж болох юм байна. Ийм ялгавартай ялын бодлого энэ дээр.

Тэгэхээр шүүх энэ дээр яаж хандах нь тухайн гэмт хэргийн үйлдлээс болох л байх л даа. Гэхдээ би энэ дээр ерөөсөө ингэж ялгавартай олон эсхүл гэж яаж ч болохоор, яаж ч хэрэглэж болохоор, ямар ч ял оногдуулж болохоор, бүр тэр хамгийн бага 12 жилийн ял ч оногдуулж болохоор хуульчлахын оронд шууд 18-аас 15 байсныг өөрчлөөд шууд бүх насаар нь хорих ял оногдуулна гээд хуульчилж болохгүй юу гэж асуух гэж байгаа юм. Үүнийг ажлын хэсгээс асууж байна.

Ер нь энэ дээр ийм төрлийн гэмт хэрэг хийсэн этгээдэд энэ хүний эрхийн тухай асуудал энэ тэр ярих боломжгүй л гэж би ойлгодог. Нийгэмд ч тийм

ойлголттой байгаа байх гэж би бодож байна.

Сүүлийн үеийн мэдээллийн хэрэгслээр гарч байгаа энэ гэмт хэргийн талаарх статистик тоо баримтуудыг харахад зайлшгүй энэ ялын бодлогыг чангатгахаас өөр аргагүй байдал үүсэж байна.

Нийгмийн тодорхой хэсэгт ч энэ ялын бодлогыг чангатгах асуудлыг дэмжиж байгаа гэж би ойлгож байна.

Ер нь нийгмийн захиалга ч байгаа болов уу. Тодорхой хэсгийнх нь захиалга. Сая сүүлийн үед гарсан гэмт хэргүүдийг харж байхад олон нийтийг цочроосон аймшигтай гэмт хэргүүд гарлаа шүү дээ.

Тэгээд үүнийг энэ мэдээллийн хэрэгслээр дамжуулж байгааг харахад энэ гэмт хэрэгтний эрхийг нь хамгаалаад байдаг юм уу, яадаг юм тэр зураг хөрөгтэй нь тавиад олон нийтэд сэрэмжлүүлэг өгөх ийм асуудал хөндөгдөөд байгаа юм.

Би яг энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдийн тэр эрхийн тухай асуудал ярихын оронд харин энэ этгээдүүдээс болгоомжилсон сэрэмжлүүлсэн энэ асуудал, мэдээллийг тавихдаа зураг хөрөг, нэр, овог нэртэй нь маш тодорхой гийтэд ил тавивал энэ чинь бас л дахин ийм төрлийн гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх нэлээн боломжит арга хэрэгсэл гэж би ойлгож байгаа юм.

Тийм учраас нэр, усыг нь, зураг хэргийг нь олон түмэнд ил болгодог асуудлыг ер нь цаашдаа яах юм бэ? Ийм байж болдоггүй юм уу гэсэн ийм хоёр асуултыг ажлын хэсгээс асууя. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Б.Энхбаяр сайдын микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Би Ц.Сэргэлэн гишүүний хоёр дахь асуултад хариулъя.

Нэг дэх асуултад ажлын хэсгийн гишүүн Б.Гантуяа хариулна.

Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн этгээдэд сая хэлсэнчлэн ялын бодлогыг чангална.

Тэгээд бүр ял шийтгэгдээд, ялаа эдлээд гарлаа гэж үзэхэд тухайн этгээдэд хорих ял ногдуулсан ялын 50 хувьтай тэнцэхүйц хугацаагаар цахим хяналтад авна гэдэг хуулийн өөрчлөлтийг дагуулж орж ирж байгаа.

Тухайлбал, 20 жилийн хорих ял шийтгэгдсэн этгээд байлаа гэж үзэхэд хорих 20 жилийн наана суллагдахгүй, магадлангаар орохгүй. 20 жилийн ялаа эдэллээ. Гарч ирлээ гэхэд 10 жилийн хугацаагаар цахим гавтай явна. Байнгын хяналтад байна.

Энэ үйл ажиллагаанд цагдаагийн байгууллага хяналт тавина.

Мөн таны хөндсөн тухайн бага насны хүүхдийн хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн үйлдэл давтагдах магадлалтай.

Түрүүн хэлсэнчлэн энэ бол өвчтөн. Сэтгэцийн өвчтэй хүн гэж үзэж байгаа учраас энэ этгээдийн мэдээллийг ил тод, мэдээллийн хэрэгсэлд байршуулна гэдгийг мөн холбогдох дагуулж орж ирсэн хууль дээр бас оруулж ирж байгаа гэдгийг танд хэлье.

Эхний асуултад 4 номерын микрофон. Б.Гантуяа хариулна.

Д.Цогтбаатар: Б.Энхбаяр дарга аа, микрофоныг би өгнө шүү эндээс. Та өгөхгүй. 4 номерын микрофоныг өгье.

Одоо хажуугаас өөр хүн микрофон хэлбэл манайхан микрофоныг нь өгөхгүй шүү.

Б.Гантуяа: Ажлын хэсгийн гишүүн Б.Гантуяа, Ц.Сэргэлэн гишүүний асуултад хариулъя.

Эрүүгийн хууль хууль зүйн техникийн бичилтийн хувьд ялын интервалуудаа 10-аад төрлийн хэмжээнд ялгаж авч явсан байдаг.

Тэгээд үүндээ онц ноцтой, хүнд зарим хэргүүд дээр бүх насаар хорих ялыг авч явсан байдаг.

Өөрөөр хэлэх юм бол хорих ялын хамгийн дээд хэмжээг оногдуулж байгаа ялын интервал буюу одоогоор төсөл дээр орж ирж байгаа 12-оос 25 жилийн хорих ялтай хэргүүд дээр дандаа бүх нас насаар хорих ялыг авч явсан байгаа.

Энэ нь Монгол Улс Эрүүгийн хуулиасаа цаазаар авах ялыг халсантай холбоотойгоор хугацаагүй хорих ялыг бүх насаар хорих ял болгож оруулж ирсэн ийм ял байгаа.

Тэгэхээр энэрэнгүй ёсныхоо зарчим, Үндсэн хуульд заасан хүний эрхийг дээдлэх зарчмуудынхаа хүрээнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд боломж олгох зорилгоор ялын интервалыг өргөн хүрээнд тавьж өгсөн байгаа. Яагаад гэвэл үйлдэгдэж байгаа гэмт хэргүүд маань өөр өөрийн гэсэн онцлог нөхцөл байдлуудтай. Хүндрүүлэх болон хөнгөрүүлэх нөхцөлүүдтэй байдаг учраас ийм ялын интервалуудыг дандаа давхар авч явдаг. Хууль зүйн техникийн хувьд ийм бичилттэй гэсэн үг.

Тэгэхээр одоогоор 12-оос 25 жилийн хорих ял оногдуулахаар заасан

ялын интервал маань Эрүүгийн хууль дээр байгаа хамгийн хүнд төрлийн интервал ялын хэмжээ байгаа. Тэгээд энд бүх насаар хорих ялыг дандаа давхар авч явж байгаа.

Бүх насаар хорих ялыг дангаар оногдуулахаар заасан хэрэг Эрүүгийн хуульд ерөөсөө байхгүй байгаа.

Тэгэхээр хууль зүйн техникийн бичилтийн хувьд энэ бичилтийг авч явсан.

Дээрээс нь нэмж хэлэхэд хүчиндэх гэмт хэргийн маань бага насны хүүхдийг хүчиндэх зарим үйлдлүүд маань Эрүүгийн хуулийн 12.5 дугаар зүйлд заасан 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох зарим хэргүүдтэй үйлдэл нь давхацдаг онцлог шинжүүдтэй.

Энэ дээр ялангуяа гэмт хэрэг үйлдсэн этгээд нь 14 наснаас доош байгаа тохиолдолд энэ хэргүүд дээр шалгах онцлог нөхцөлүүд байдаг учраас ийм интервалууд хамт яваа юм.

Д.Цогтбаатар: Ш.Раднаасэд гишүүн асуултаа асууя.

Ш.Раднаасэд: Хоёр, гурван тодруулах зүйл байна.

Энэ согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчил гаргаж байгаа хүмүүсийн насны судалгаа байна уу?

Одоо энэ чинь жилд ойролцоогоор 35-аас 2022 онд бол бүр 54900, бараг 55 мянган хүн байгаа юм. Энэ дан залуучууд л голцуу байгаа. Нас, хүйсээрээ гарч байвал эмэгтэйчүүд ч цөөхөн байгаа байх.

Нийтэд нь жоохон эрүүгийн ял шийтгэлтэй, гэмт хэрэг үйлдэж байсан гэдэг ийм тодорхойлолттой л үлдээх гээд байна л даа.

Энэ үр дагаврыг нь яах вэ? Хэдийгээр үүнийг зөвтгөөгүй. Би бол. Уг нь болдог бол үүнийг чангатгачихмаар байгаа юм. Гэхдээ жоохон нарийсгамаар байна. Үүнийг.

Одоо гадагшаа явахад визний мэдүүлэг мэдүүлэхэд гэмт хэрэг үйлдэж байсан юм байхгүй. Шүүгч, прокурор хийх ямар ч боломжгүй, цагдаагийн байгууллагад ажиллах ямар ч боломжгүй. Ингээд бүх насаараа тэр үр дагаврыг амсах гээд байгаа байхгүй юу. Нэг дэх юм.

Хоёр дахь юм нь, энэ хуулийн хэрэгжилтийг ер нь яг яаж харж байна?

Зарим хуульчид бол ингээд нэг тэнсэн аваад ингээд өнгөрчихнө гэж. Энэ явж явж шүүх дээр маш их хэмжээний маргаан чирсэн юм явна.

Сүүлдээ энэ цусны шинжилгээ рүү орно шүү. Баталгаагүй аппаратаар хэмжсэн байна, цусны шинжилгээ өгнө. Тэгээд тэр шинжилгээ нь яг өмнөхтэйгөө ижил байх уу, үгүй юу. Ингээд л юм цаашаа өрнөнө дөө.

Тэр даруйд нь буцах аргагүйгээр, хэлэх үггүйгээр шийдэх боломжтой бол тэр шийдэх арга зам руу нь явуулаад.

Ер нь энэ согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохыг яаж таслан зогсоох вэ. Тэр арга хэмжээг л хурдан авах хэрэгтэй.

Хэт их чангалснаараа сайн талтай ч гэсэн муу талтай шүү. Тэр 30-аад оны Америкийн хуурай хууль гэдэг өөрөө

хэнийг баяжуулсан юм гэхээр хуулийн байгууллагынхныг, зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлийг л баяжуулсан.

Өнөөдрийн ханшаар 1.6 тэрбум долларын ашгийг зөвхөн тэр хуулийн хэрэгжилтээс болж хийсэн гэж яриад байдаг юм шүү дээ.

Тэгээд ер нь яаж одоо өөрчлөх вэ? Эдийн засгийн хөшүүргийг нь өсгөж мөнгөн дүнг нь, торгуулийн хэмжээг нь ихэсгэх үү гэдэг юмыг л асуух хэрэгтэй байна.

Хоёрдугаарт нь, энэ бага насны хүүхдийн хүчиндэх гэмт хэрэгт. Ер нь энэ хүүхэдтэй холбоотой юмаа цогцоор нь оруулж ирж болоогүй юу?

Одоо энэ эцэг, эх байх, халамжлах үүргээ гүйцэтгээгүй, бага насны бага насны хүүхэдтэй зүй бусаар харьцсан, хандсан, ямар ч өөр өөрийгөө хамгаалах чадваргүй ийм нөхцөл байдалд л аваачиж хүүхдийг хүчээр хөдөлмөрлүүлэх ч гэдэг юм уу. Одоо энэ маш олон зүйл ангиуд байсан. 2002 оны хуульд.

Бид энэ сүүлийн хуулиар үүнийг чинь өөрчлөөд бүр хумиад хаячихсан шүү дээ. 11, 12 зүйл байсан. Ямар ч байсан.

Тэр нь сүүлийн 2017 оны хуулиар, 2015 оны хуулиар их багасгачихсан. Үүнийг иж бүрнээр нь л би хиймээр харагдсан юм.

Өнөөдөр ганц шуугиан гарангуут.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Б.Энхбаяр сайдын микрофоныг өгье. Нэгмөсөн Ш.Раднаасэд гишүүнд тэгвэл нэмэлт хугацааг нь өгчихье.

Ш.Раднаасэд: Энэ зүйлүүдийг ер нь яах ёстой вэ?

Хоёрдугаарт, би энэ Зөрчилийн хууль дотроос нэг зүйл асууя. Энэ ямар учиртай үүнийг нэмээд оруулаад ирэв?

Энэ зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд, албан тушаалтан шүүхээс оногдуулсан торгох шийтгэлийг хуулиар тогтоосон хугацаанд биелүүлэх бол шийтгэлийн хэмжээг нь 50 хувиар хөнгөрүүлнэ гэж.

Эрх хасах, албадан хөдөлмөрлүүлэх, одоо юу байна. Хорих. Одоо тэгээд энэ чинь мөнгөгтэй болбол бага шийтгэл хүлээдэг. Мөнгөгүй болбол яг шүүгчийн уншсан хэмжээгээр зөрчлийн хариуцлага хүлээнэ гэсэн нэг ийм л агуулга үүний цаана яваад байгаа юм.

Энэ 3.5 дээр орсон чинь би эвсвэл буруу.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Б.Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодоод зөрчлийн шийтгэл авсан хүмүүсийн нас, хүйсийн судалгаа байгаа эсэхийг. Надад бол байхгүй байна. Тийм юм ер нь байдаггүй байх. Зөрчлийн тухайтад.

Гэмт хэрэг болсон тохиолдолд энэ дэлгэрэнгүй гарах бололцоотой байх гэж бодож байна.

Ш.Раднаасэд гишүүний болгоомжилж хэлж байгаа үр дагавар нь нэн их. Тантай санал нэг байна.

Өөрөөр хэлбэл тухайн согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодоод гэмт хэрэг үйлдэгдсэн тохиолдолд үүний хууль зүйн

үр дагавар их. Тухайлбал, цагдаагийн байгууллага, шүүгч, прокурор болох гэж байгаа хүмүүст огт гэмт хэрэг үйлдэж урьд нь байгаагүй байх гэдэг хууль зүйн шалгуур байдаг.

Тэгэхээр энэ шийтгэгдсэн этгээд ер нь ийм ажлууд хийх бололцоогүй болно л гэсэн үг.

Түүнчлэн улс төрийн албан тушаалтнуудад ч гэсэн гэмт хэрэг үйлдэж шүүхийн шийтгэх тогтоолоор нотлогдох юм бол тухайн сонгуульт албан тушаалтныг эгүүлэн татах ийм Үндсэн хуулийн үр дагаврууд байдаг.

Тэр утгаараа энэ бол Улсын Их Хурлын гишүүдээсээ эхлээд хууль зүйн үр дагавар нь тухайн албан тушаалаас нь огцруулах хүртэл хууль зүйн үр дагаврыг үүсгэж байгаа гэдгээрээ энэ бол ганцхан зүгээр торгуулийн асуудал биш гэдгийг би зориуд онцолж хэлье.

Ганцхан шийтгэхтэй холбоотой асуудлыг сая хэлсэнчлэн ялын хувьд 4 төрлийн сонголт байна.

Шүүх мэдээж тухайн этгээдийн онцлог нөхцөл байдалтай холбож аль ял шийтгэлийг сонгож хэрэглэх вэ гэдгийг мэдээж хийнэ.

Миний бодлоор гол төлөв торгох, нийтэд тустай ажил хийлгэх ялуудыг шүүх илүү түлхүү хэрэглэх магадлалтай гэж үзэж байгаа. Тийм.

Өөрөөр хэлбэл энэ үйлдэлд илүү тохирсон ял шийтгэлийн бодлого ч байж болно.

Ер нь тэгээд дахин давтан гаргаад байгаа этгээдүүдийн тухайд тэгээд л хорих ял руугаа л орж таарах байх. Энэ бол шүүхийн тухайн хэргийн давтамж,

нөхцөл байдлуудаас хамаарч хэрэглэгдэх байх.

Ер нь торгуулиас гадна хүүхдийн асуудал дээр эцэг байх үүргээ биелүүлээгүйтэй холбоотой асуудлыг Засгийн газар ирэх долоо хоногийн хуралдаанаараа Гэр бүлийн тухай хуулийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн барина.

Энэ хуулийн төслөөр үүнтэй холбоотой асуудлуудыг цогцоор шийднэ.

Өнөөдөр Монгол Улсын Дээд шүүх Засгийн газраас өргөн барих гэж байгаа Гэр бүлийн тухай хуулийн төслийг хэлэлцэж байгаа. Яг одоо.

Ингээд Улсын дээд шүүхийн саналыг авсны үндсэн дээр Засгийн газар Улсын Их Хуралд өргөн барих нь зүйтэй гэсэн учраас нэг долоо хоногийн хугацаагаар хойшлоод ирэх долоо хоногт Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэхээр болсон байгаа.

Ер нь 2015 оны Эрүүгийн хуулиар давтан гэмт хэрэг гэдэг ойлголт байхгүй болсон байгаа. Түүнтэй холбоотойгоор ялгүйд тооцох хугацаа гэж хуучин 2002 оны хуульд байсан энэ ойлголт шинэ Эрүүгийн хуулиар байхгүй болсон.

Өөрөөр хэлбэл ялаа эдэлж дууссаны дараа тодорхой хугацаанд ял шийтгэлгүйд тооцогддог ийм хугацаанууд ойлголт байдаг байсан. Ийм ойлголт үр дагавар байхгүй.

Таны хэлсэн одоо жишээлбэл гадаад улс орны визэнд ороход энэ нөлөөлнө.

Өөрөөр хэлбэл урьд нь гэмт хэрэг үйлдэж ял шийтгэж байсан уу, үгүй юу

гэдэг асуудлыг гадаад улс орнууд бас хуудсаараа бөглөдөг.

Тийм учраас ер нь согтуугаар тээврийн хэрэгслээ жолоодохоо больцгоох нь л аминд өлзийтэй болж байгаа шүү гэдгийг л хэлье.

Д.Цогтбаатар: Ж.Сүхбаатар гишүүн асуултаа тавья.

Ж.Сүхбаатар: Би асуултаа тавихаас өмнө бас нэг зүйл хэлэхэд.

Ер нь 2020 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлуулахад би энэ архидан согтуурахтай холбоотой заалт байхгүй байна гээд архидан согтуурахтай хийх тэмцлийг эрчимжүүлж, энэ архинд донтсон улсуудыг эмчлэх наркологийн төвийг бэхжүүлэх тухай асуудлыг тэнд тусгаж батлуулж байсан юм.

Тэгээд үүний араас сая Ц.Мөнх-Оргил гишүүн ахлаад манай Хууль зүйн байнгын хорооны гишүүд бид ороод Ерөнхийлөгчийн санаачилсан Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг баталсан.

Үр дүн нь гарч байх шиг байна. Сая Хууль зүйн сайд 1.3 сая литрээр борлуулалт буурсан байна гэж байна л даа.

Хүний амь нас хохироосон тохиолдол 2022 онд хоёр дахин буурсан гээд.

Ямар ч гэсэн бид нарын тэмцэл эрчимжиж байгаа үйл ажиллагааны үр дүн ерөнхийдөө харагдаж байна. Зүгээр дотор нь детальчлаад тодорхой чиглэл чиглэлээр нь салгавал ямар гарах юм мэдэхгүй.

Би тэгээд нэг юм хэлэх гээд байгаа нь сая өнгөрсөн жил сайдаар ажиллаад хэд хоногийн дараа танилцаж байхад 30 мянган жолоочийн эрх хасагдаж байгаа гэж байгаа байхгүй юу.

Тэгэхэд тэр нь эргээд баригдаж байгаа хүмүүс нь би итгээгүй. 20 мянган жолооч жолоодох эрхээ хасуулсан хүн буцаад баригдаж байна гэж байгаа юм.

Тэгээд баригдахгүй цаад хэдтэй нь үлдэх юм бол жолооны эрх хассан тэрний нөлөө байхгүй. Тэгээд торгосон торгуулиа удаа дараа торгуулиа төлөөгүй 40, 50 сая төгрөг хүрчихсэн, 100 удаа, бараг ерэн хэдэн удаа торгуулчихсан. Одоо багасчихсан байна лээ. Нэлээн ажил зохион байгуулаад.

Ингээд торгоод торгоод торгуулиа төлдөггүй бас ийм улсууд. Зарим нь болохоор яах вэ би торгуулиа мэддэггүй, надад өгдөг ч үгүй, би хардаг ч үгүй гээд.

Тэгэхээр ийм ийм байдлууд үүсээд энэ авто тээврийн ослын асуудлууд, энэ зөрчлийн асуудал буурахгүй байсан.

Тэгээд сая яах вэ зүгээр ерөнхийдөө архидаан согтуурах үзэгдэл нэлээн буураад. Сая Хууль зүйн сайдыг энэ асуудлыг оруулж ирнэ гэсэн бараг ярианы сургаар сүүлийн хэд хоногууд чинь согтууруугаар жолоодож байгаа хэрэг зөрчил чинь их буурчихсан байгаа гэж байна шүү дээ.

Тэгэхээр ер нь энэ Эрүүгийн хууль чинь өөрөө залхаан цээрлүүлэх чиглэлээсээ гадна урьдчилан сэргийлэх чиглэлтэй.

Ер нь энэ чинь яг онолынх нь хэллэгээр айлган сүрдүүлэх зорилго бас байдаг юм шүү дээ. Хичээл ном дээр

заахад. Яах вэ, бид тэрийг урьдчилан сэргийлэх гэж хэлдэг.

Тэгээд үүний нөлөө бий. Тэгэхээр үүнийгээ бид бас ингээд чангатгаад явах нь зөв.

Зүгээр тэр согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон болгон хоригдоно гэж байхгүй л дээ. Түрүүний хэлдгээр зорчих эрхийг нь хязгаарлах, нийтэд тустай хөдөлмөр эрхлэх, торгуулийн ял гээд эд нарыг нь хэрэглэнэ.

Түрүүний тэр Ш.Раднаасэд гишүүний хэлээд байгаа шиг зарим улсууд маань ялгүйд тооцдог юм байхгүй болчихсон. Ялтайд тооцогдоод ингээд явдаг зүйл байгаа шүү гэж байна.

Үүнийгээ хууль хэрэглээд явах явцын дунд бас үүнийгээ, одоо түрүүн Б.Энхбаяр сайдын хэлдгээр энэ согтуугаар жолоодож байгаа улсууд буурах ёстой. Гэхдээ бас тийм нөхцөл байдал амьдралын дунд харууштай, бодууштай юм гарвал бид жилийн дараа үүнийгээ хэрэглээний байдлыг харж үзэхэд би буруу биш байх гэж бодож байна.

Ямар ч байсан тэгэхдээ өнөөдөр үүнийгээ явуулах ёстой.

Тэгээд би юу асуух гээд байна вэ гэхээр иргэдийн асуугаад байгаа юм их энгийн байгаа юм. Ерөнхий хуулийн заалтыг нь хар.

Тэгээд нэг айраг уучихдаг, пиво уучихдаг. Одоо тэгээд яах юм бэ гэж.

Тэгэхээр та хэдийн тэр цусан дахь спиртийн байгууламж 0.5 промилл гэдэг чинь одоо ямар хэмжээний айраг уучихсан, архи уучихсан, пиво уучихсан хүн таарах вэ?

Амьсгал дахь спиртийн агууламж 0.20 промилл илэрвэл согтууруулах ундаа хэрэглэсэнд тооцно гээд байна шүү дээ.

Тэгэхээр үүнийг чинь иргэд энэ тоог яаж тооцоолж гардаг юм бэ гээд. Олон хүний санаа зовоосон маргаантай асуудал тийм байх шиг байна лээ. Гараад нэг айраг уучхаад гараад явчихдаг. Тэгтэл тэр нь шууд согтууруулах ундаанд тооцох уу гэж.

Тэгэхээр яг манайхны судалгаа юм хум юу байдаг юм бол. 0.2, 0.5 промилл гээд. Зарим улсад болохоор ганц шар айраг уухад болдог ч гэдэг юм уу ингээд л яриад байна шүү дээ.

Тэгэхээр энэ талаар манайхны явж ирсэн энэ талаар иргэдэд мэдээлэх үүднээс нь энэ дээр нь нэг тодорхой хариулт өгөөч.

Тэгээд би нэмээд нэг юм хэлье гэж бодож байна. Дараа нь.

Д.Цогтбаатар: Б.Энхбаяр сайдад микрофоныг нь өгье.

Б.Энхбаяр: Согтуурлын хэмжээтэй холбоотой асуудлыг ажлын хэсгээс нэмж хариулаарай.

Бусад улс орны яг энэ согтуурлын хэмжээн дээр тавьдаг хэмжээ байсан. Түүнтэй холбоотой харьцуулсан судалгаа хийгдсэн байгаа. Тэрийг ажлын хэсгээс нэмж хариулаарай.

Мөн тэр эрхгүй этгээд буюу жолоочийн эрхээ хасуулсан этгээд дахин дахин бариад байгаа асуудал нэлээн хавтгайрсан шинжтэй байгаа. Энэ дээр тодорхой ялын бодлого орж ирж байгаа. Шинээр.

Үүнийг мөн ажлын хэсгээс нэмж хариулаарай.

Ер нь Эрүүгийн хуулийн ял шийтгэлийн бодлого гурван үндсэн зорилготой байдаг.

Нэгдүгээрт, тухайн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх.

Хоёрдугаарт, хүмүүжүүлэх.

Гуравдугаарт, ерөөсөө гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх гэсэн ийм гурван үндсэн зорилгыг чиглэдэг.

Мэдээж согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох үйлдлийг гэмт хэрэгт тооцох ялын бодлогыг чангаруулж байгаа нь энэ гурван зорилгод гурвууланд нь чиглэж байгаа.

Тухайлах юм бол миний бие өнгөрсөн долоо хоногийн Даваа гарагт хоёр намын бүлэгт танилцуулга хийсний дараа хамгийн анх тээврийн хэрэгслийг согтуугаар жолоодвол гэмт хэрэгт тооцно гэдгийг иргэд, олон нийтэд мэдээлсэн. Яг долоо хонож байгаа.

Энэ долоо хоногийн хугацаанд согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил өмнөх долоо хоногтой харьцуулахад 42-оос 47 хувь буурсан байгаа. Эрс багассан гэсэн үг.

Тэр ч утгаараа хэдийгээр бид хуульд батлагдаагүй өнөөдөр дөнгөж хэлэлцэх эсэх асуудлыг нь ярьж байгаа ч гэсэн урьдчилан сэргийлэх зорилгоо аль хэдийнээ өгөөд эхэлж байгаа.

Ер нь цаашдаа энэ ялын бодлого тогтвортой мөрдөгдөөд ирвэл хууль бол өөрөө дадал болж байх ёстой. Хүний зан үйлд тогтвортой үйлчлээд, 5 жилийн

хугацаанд үйлчлээд ингээд явчих юм бол энэ бол зөв дадал болж хэвшинэ.

Ер нь жоохон юм уучхаад л тэгээд л машин бариад л явдгаа л болих хэрэгтэй. Энэ бүр оюун ухаанаас нь бүр арчигдах ёстой.

Тухайлбал, бид тамхины эсрэг хуулийг анх хэлэлцэж байх үед хүмүүс энэ хэрэгжих болов уу, үгүй болов уу. Бас л хуурай хууль гарах болов уу гэж их ярьж байсан.

Ингээд тамхины эсрэг хуулийг харахад одоо үйлчилгээний газруудад, хоолны ресторануудад, ер нь хүмүүс тамхи татахаа больчихсон. Хуучин чинь ингээд л нэг манан будан дотор л хоолоо идээд л суудаг байсан шүү дээ. Хэвийн зүйл.

Одоо бол хүмүүс цочно. Одоо бол.

Тэгэхээр хууль тогтвортой мөрдөгдөөд эхэлбэл нийгмийн амьдралд дадал болно. Мөн соёл болно.

Тийм учраас хууль тогтоогчийн бас нэг зорилго энэ буруу үйлийг ер нь таслан зогсоох чиглэлд хуулийн хатуу гараар үзэхээс өөр арга байхгүй.

Нөгөө **Макиавелли**^[Machiavelli's Prince: A lion and a fox]-ийн хэлсэн хоёр арга байдаг. Арслангийн аргаар ч үзэх ёстой, үнэгний аргаар ч үзэх ёстой гэж.

Яг энэ согтуу жолооч дээр бид арслангийн аргаар үзэх гэж байгаа юм. Тийм.

Д.Цогтбаатар: Ажлын хэсэгт микрофонд шилжүүлье. 5 номер уу? Л.Нямдаваа.

Л.Нямдаваа: Гишүүний асуултад нэмж тодруулъя.

Цагдаагийн ерөнхий газар. Л.Нямдаваа.

Өнөөдрийн байдлаар Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны хамтарсан тушаалаар Жолооч согтууруулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг шалгах журмын дагуу тандагч драгер багажаар хэмжиж байгаа. Энэ бол амьсгалдаг агаарын хэмжээг 0.20 бүхлээр тооцож явж байгаа.

Ер нь Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 4 дүгээр зүйлд согтууруулах ундаа гэж хүнсний зориулалт бүхий түүхий эдээр үйлдвэрлэгдсэн спирт 2 хувиас дээш хатуулагтай нэршлээс үл хамаарсан бүх төрлийн архи, дарс, шар айраг зэргийг ойлгохоор хуульчилсан байгаа.

Олон улсад согтууруулах ундааны дундаж хэрэглээ хэмээх ойлголтыг улс орон бүр өөр өөрөөр авч үздэг.

Нэг хундага зохистой хэрэглээг Америкийн Нэгдсэн Улсад 14 грамм алкоголь гэж тооцдог бол Японд 19.75 грамм байх жишээтэй.

Ер нь стандартыг пиво бол 350 миллиграмм байхад 5 хувийн алкогольтой байдаг гэж үздэг. Архинд 44 миллиграммд 40 хувийн алкоголь, дарсанд 150 микрограммд 12 хувийн алкоголь гэж үздэг. Коктейльд 122 миллиграммд 5 хувийн алкоголь гэж үзсэн байдаг.

Тэр айраг уусан хэмжээнээсээ биш тухайн хүний нөгөө биеийн онцлог, хүлээж авах чадвараас болж шалтгаалж согтолтын зэрэг янз янз гардаг юм билээ.

Д.Цогтбаатар: Бас нэг асуулт байсан уу? Хариулт болсон уу? Ж.Сүхбаатар сайд.

Нэмэлт асуух уу? Тэгье. Ж.Сүхбаатар гишүүн.

Ж.Сүхбаатар: Яах вэ, нэмэлт асуулт гэхээсээ гадна.

Тэгэхээр энэ хууль маань хэзээ хэрэгжих юм бэ гэхээр 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс гээд орж ирсэн байна. Энэ зөв байх.

Б.Энхбаяр сайд хэлж байна шүү дээ. Үр дүнгээ өгч байгаа гэж байна.

Тэгэхээр “**замын хөдөлгөөний танхайрал**” гэдэг үгийг би энэ өнгөрсөн жил 9 сараас хойш оруулж ирсэн юм.

Ер нь манайхан чинь бараг толгой элээд, Зөрчлийн хуулиар ер нь сануулдаг больё гэсэн заалттай юм орж ирсэн шүү дээ. Ер нь. Хэдийгээр чангатгая гэж байсан ч гэсэн.

Тэгээд сүүлийн нэг жил би “замын хөдөлгөөний танхайрал” гэж ярьсан. Олон нийт, хэвлэл мэдээллийнхэн ойлгосон. Энэ замын хөдөлгөөний танхайралыг бүрэн таслан зогсоох шаардлагатай.

Тэгэхээр хатуу арга хэмжээ авах нь зөв. Тэгэхдээ үүнийг маш их. Одоо түрүүн хэлж байна шүү дээ. Нөгөө урьдчилан сэргийлэх хүмүүжлийн нөлөөтэй гэж байгаа бол энэ замын хөдөлгөөний танхайралын эсрэг кампанит ажлыг энэ өвөл маш хүчтэй хийх хэрэгтэй. Одоо байгаа яг энэ хууль мөрдөгдөхөөс өмнө байгаа хууль тогтоомжоо хатуу мөрдүүлэх хэрэгтэй. Тэгвэл тэр түгжрэл буурна, тэгвэл тэр

стресс буурна, тэгвэл тэр сахилгатай болно.

Ер нь замын.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Ц.Мөнхцэцэг гишүүн асуултаа асууя.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр Хууль зүйн сайдын өргөн барьж байгаа хүүхдийн эсрэг хүчирхийллийн гэмт хэрэг, мөн согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон этгээдэд үзүүлэх ялын бодлогыг чангатгах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж байна.

Тэгээд бас хэд хэдэн асуулт байна. Энэ дотор одоо нөгөө гэр бүлийн хүчирхийллийн эсрэг, тэгээд хүүхдийн хүчирхийллийн эсрэг ялын бодлогууд чангарах нь зүйтэй байгаа. Манай олон нийтийн дунд удаа дараа сэтгэл эмзэглүүлсэн ноцтой гэмт хэргүүд гарч байна. Тэр гэмт хэрэгтнүүд маань мөн урьд өмнө удаа дараа ял эдэлж байсан ийм нөхдүүд байгаа.

Тийм учраас хөөн хэлэлцэх хугацааг 30 жил болгож сунгах. Тэгээд хүүхдийн эсрэг хүчирхийллийн гэмт хэрэгтнүүд тэнсэн харгалзах болон бусад хугацаанаасаа өмнө суллах энэ боломжуудыг бүгдийг нь арилгаж байгаа ялын бодлого маань шударга ёсонд нийцэж байгаа ийм дэвшил байгаа.

Тэгээд энэ дээр нэг анхаарах зүйл байна.

Одоо ингээд бид ялын бодлого чангарч байгаа маань тухайн гэмт хэргийн хохирогч, гэрчүүдийн аюулгүй байдлыг хангах, хохирогчийн нууцыг хамгаалахад саад учруулах вий.

Тухайлбал, саяхан бид болж өнгөрсөн энэ өмнөх хүүхдийн амь нас эрсэдсэн асуудлууд дээр хохирогчийн нууцыг олон нийтээр ил мэдээлэх, гэр бүлийнхэн удаа дараа хэвлэлийн бага хурал хийж тухайн хохирогч охины юунд халдсан, урьд өмнө нь ийм хүчирхийлэлд өртөөгүй байтал хүчирхийлэлд өртсөн болгож зарлалаа гэх мэтээр гэрч, хохирогчийг хамгаалах асуудал маань хаягдаад байна.

Энэ бол гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэгээд гэмт хэргийн улмаас хохирсон хүмүүсийнхээ эрхийг сэргээх чухал асуудал байгаа.

Тийм учраас хууль тогтоогч бид, мөн Хүний эрхийн дэд хороонд нэлээд олон иргэд, экспертүүд, мөн хохирогч нарын зүгээс хуучны Тахарын албыг сэргээх, шүүгч, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, гэрч, хохирогчийг хамгаалах асуудал дээр ер нь Тахарын албыг сэргээх нь зүйтэй гэсэн ийм байр суурь нэлээд ирж байгаа.

Тийм учраас Хууль зүйн сайд ажлын хэсгийнхнээс гэрч хохирогчийг хамгаалах, тэр дотроо хүүхдийн эсрэг гэмт хэргийн хүчирхийлэл, хүний наймааны золиос болсон хохирогч нарыг хамгаалах тухай тухайд ер нь одоо байгаа үйлчилж байгаа хуулиуд маань үнэхээр хангаж чадаж байна уу, үгүй юу. Шаардлагатай бол энэ Тахарын албыг сэргээх нь зүйтэй юу, үгүй үгүй юу гэдэг дээр байр суурийг сонсмоор байна.

Дээрээс нь, Эрүүгийн тухай хуулийг дагалдуулаад Иргэний хуулийн тодорхой заалтуудыг оруулж ирж ер нь болохгүй юу? Тухайлбал, хохирогч хүүхдэд учирсан эдийн болон эдийн бус гэм хорыг арилгах. Тэгээд урт хугацааны ийм сэтгэл зүйн болон бусад дэмжлэг үзүүлэх энэ тухайд Иргэний хуулийн

холбогдох заалтуудыг ер нь дагаж өргөн барих уу, үгүй юу?

Ер нь бид ялын бодлого чангатгахаас гадна гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мөн тухайн гэмт хэргийн золиос болсон гэрч, хохирогч нарыг хамгаалах, тэд нарын зөрчигдсөн эрхийг сэргээх нь төрийн үүрэг учраас энэ тал дээр Хууль зүйн сайдын байр суурь болон Ажлын хэсгийн байр суурийг ер нь сонсох нь зүйтэй болов уу гэж үзэж байна.

Д.Цогтбаатар: Хууль зүйн сайд.

Б.Энхбаяр: Ц.Мөнхцэцэг гишүүн маань санаачлаад хүүхдийн эсрэг ялын бодлоготой холбоотой асуудлаар Хууль зүйн байнгын хороон дээр парламентын хяналтын сонсгол хийхээр санаачилга гаргаад Байнгын хороо маань шийдээд 20-д гаргаад хийнэ.

Тэгээд энэ дээр санаачилгатай хамтарч ажиллаж байгаад танд талархлаа илэрхийлье.

Хүүхдэд ер нь учирч байгаа сэтгэл санааны гэмтэл гэдэг хамгийн аюултай.

Тийм ч учраас бусдыг санаатай алах, бага насны хүүхдийн хүчирхийлэл, аллагатай холбоотой мэдээ мэдээллийг олонд түгээх, энэ хохирогчийн зураг, хувийн мэдээлэл, нэр ус, хаяг. Энэ юмыг түгээх асуудал дээр нэлээн хязгаарлалт тавигдаж явагдах учиртай байдаг. Яагаад гэхээр тэр хүүхэд маань насанд хүрч таарна.

Тийм учраас бид бас нэг удаагийн үйлдлийн давхар ирээдүйтэй нь хамт нийгмээрээ алдаг байж таарахгүй гэж үзэж байгаа.

Энэ сэтгэл санааны хохирлыг хаврын Улсын Их Хурлын чуулганаар энэ онд манай Э.Бат-Амгалан гишүүн ахлаад Шүүхийн шинжилгээний тухай хуулийг баталсан.

Энэ хуулиар Монгол Улсад анх удаа хохирогчийн сэтгэл санааны хохирлыг тооцдог, мөнгөөр үнэлж барагдуулдаг ийм эрх зүйн орчин бүрдсэн байгаа.

Хууль 7 сарын 01-нээс үйлчилсэн.

Энэ хэрэгжиж эхэлснээс хойш 3 сарын хугацаанд шүүхийн шинжилгээний байгууллага 50 орчим хохирогч хүүхдийн сэтгэл санааны хохирлыг мөнгөөр тооцож гаргасан байгаа.

Бид мэдээж анх удаа учраас аргачлал юман дээр мэдээж боловсронгуй болж явна.

Тэгэхдээ ямар ч байсан урьд нь огт тооцдоггүй, огт хэрэглэдэггүй байсан сэтгэл санааны хохирлыг нь мөнгөн дүнгээр үнэлж арилгахтай холбоотой асуудал ямар ч байсан Монгол Улсад эхэлсэн.

Цаашдаа энэ дээр зүгээр нарийн мэргэжлийн сэтгэл зүйчдийг тогтвортой бэлдэх, мөн тогтвортой ажиллах баталгаагаар хангахтай холбоотой асуудлыг ер нь шийдэх хэрэгцээ шаардлага байгаа юм байна лээ.

Тахарын албын тухайтад миний хувьд одоогоор ямар нэгэн байр суурь илэрхийлэх бололцоо байхгүй байна.

Яагаад гэхээр Засгийн газар кабинетын зарчмаар, тэр дотроо Ерөнхий сайдын бодлыг хэрэгжүүлдэг. Би Монгол Улсын Ерөнхий сайдтай зөвшилцөөгүй асуудлаараа хувийн байр суурь гэдэг

байдлаар илэрхийлэх боломж хязгаарлагдмал байгаа гэдгийг та ойлгож хандах байх гэж ойлгож байна.

Тэгэхдээ энэ асуудлыг судалж үзнэ. Яагаад гэхээр түрүүний ярьсан тэр мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах үйлдэлд оногдуулах ялын бодлогыг чангатгах гэж байгаа зорилгын цаана гэрч хохирогчийг хамгаалах бодлого давхар явж байгаа юм. Гэрч хохирогчийг.

Тийм учраас энэ асуудал дээр анхаарч ажиллана гэдгийг танд хэлье.

Д.Цогтбаатар: Нэмж асуух юу байхгүй бол.

Өнөөдөр ер нь энэ хуулийн ялын бодлогыг чангалах тухай нэлээн чанга хандлага бүхий саналууд орж ирж байгаа.

Өнөөдөр энд Д.Ганбат гишүүн орж ирээд нэмэлт асуулт асууя гэж байна. Энэ нэлээн чухал асуудал яригдаж байгаа учраас би энэ боломжийг олгоё гэж бодож байна. Хуульд энэрэнгүй хандах, ойлгож, зохицуулж, чандах хандлага байдаг. Ялын бодлогыг чангатгахын зэрэгцээгээр.

Тийм учраас энэ дэгийн хуулийн 13.17-д заасны дагуу Д.Ганбат гишүүнд асуулт асуух боломжийг олгоё гэж бодож байна. Тэгэхдээ ийм боломж дандаа олгогдоод байхгүй гэдгийг гишүүддээ анхааруулж хэлье.

Д.Ганбат: Баярлалаа. Д.Цогтбаатар даргадаа онцгойлон.

Үнэхээр хүний эрхийн шагнал авсан ийм Улсын Их Хурлын гишүүн шиг хандаж байна. Зөв өө.

Манай Хууль зүйн яамнаас, Засгийн газраас энэ 3 хууль дээр ялын бодлогоо чангаруулахаар оруулж иржээ.

Би үүнийг ерөнхийдөө зөв гэж бодож байна. Дэмжиж байна. Цаг нь болсон хэд хэдэн хуулиуд байна. Гэхдээ бид аягүй судалгаа тооцоо ийм зүйл дээр л нэлээн. Долоо хэмжиж байж нэг огтолно л доо.

Энэ чинь нэг хэсэг юмыг аваад л өөрчлөөд байвал нөгөө Эрүүгийн хууль, эрх зүйн бодлого энэ юм хум чинь, ялын бодлого чинь ямар байх вэ.

Бид нарт гашуун туршлага байна. 2022 оны өдийд байна уу. Баахан хүний гэрээс мөнгө төгрөг гараад л нүүрсний хулгай гээд л ингэдэг. Тэгээд нийгмийг бүгд л тэгээд бараг л чангаруул, бүгдийг нь шоронд хий гэсэн ийр ийм уур амьсгал бүрдчихдэг л дээ.

Энэ дунд ажиллахад хэцүү. Тэгээд баахан л нөгөө авлига, албан тушаалын хэрэгтэй хүмүүсийн ялыг чангаруулсан. Гэтэл тэгээд үр дүн нь тойроод жил болоход ямар байна? Ногоон автобусны хэрэг гээд л ингээд л гарч байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид тэгээд бөөн шуугиан болонгуут л гэнэтхэн ингэдэг биш. Маш судалгаа, тооцоон дээр ийм юмаа хийх ёстой.

Яах вэ, ер нь тэр бага насны хүүхдийн эсрэг хийж байгаа хүчирхийлэл, энэ юм хумтай мэдээж хэрэг ярих цаг болсон. Угаасаа бид бүхэн залуучуудын орон. 18 хүртэлх насны хүүхдүүд маань бараг 50 хувь нь байгаа байх.

Тэгээд амьдрал ахуй нь хэцүү хүнд, гадагшаа дотогшоо эх эцэг нь

явдаг. Ядуурал, ажилгүйдэл энэ нийгмийн хамаг бий болсон юмтай холбоотой.

Тэгэхээр тэргүүн туршлагауд гадна дотнын орнуудад байна. Үнэхээр яалт ч үгүй **педофил**^[pedophilia]¹ хүмүүс бий. Ямар арга хэмжээ авч, яаж ажиллах юм?

Үүнээс гадна хэд хэдэн хурлууд дээр нөгөө тийм тариа байдаг. Тухайлбал, тэр хүчирхийлэл үйлдээд байдаг тэр юм хумыг нь багасгадаг, байхгүй болгодог ийм юман дээр судалгаа бий юу?

Согтууруулах ундаатай холбогдоод ярихад мэдээжийг хэрэг одоо үүнийг чангаруулах цаг болсон. Машин тэрэг ч олон болсон. Хүмүүс ч тэгээд янз бүрийн айраг энээ тэр гээд. Тийм ээ. Тэр шалтаг шүү дээ.

Машинаа тавиад л тэр айргаа ууна биз. Энэ дээр бид хатуу хандаад тэр эрүүгийн зүйл, заалтыг оруулж ирэх цаг болсон. Наана чинь хүний амь яригдаж байна, хүүхдийн амь яригдаж байна.

Тэгээд ямар нэгэн салаа утгагүйгээр ийм байх ёстой гэдгийг нь хэлээд өгчихвөл сая дөнгөж яриад эхлэнгүүт үр дүн гарч байна гэдэгтэй санал нэг байна.

Олон ч машин тэрэгтэй боллоо. Хүн болгон машин барьдаг боллоо. Үүнийг дагалдуулаад машин барих эрхгүй этгээдүүд энэ улсууд чинь ямар байгаа вэ?

¹ Сэтгэцийн эмгэг, насанд хүрээгүй хүмүүсийн эсрэг бэлгийн хүчирхийлэл.

Ер нь хүндэрвэл бүх юмыг л хүндрүүлж үзэх хэрэгтэй шүү дээ. Бараг согтуу барьчихаад би хүн дайрчихлаа. Бараг намайг хөнгөрүүлэх ёстой гэсэн ийм ойлголттой байдаг. Тэр дээр нь цэг тавьж өгөх ёстой. Энэ хамгийн хүндрүүлэх хэрэгсэл шүү гэж.

Энэ чинь хутганаас долоон доор юм барьчихаад явж байна гэсэн үг шүү дээ. Үүнийг ойлго.

Миний 1 минутыг нэмээд өгчхөөрэй.

Хүний амь хүний эрхийг бид хаана ч ярих ёстой.

Д.Цогтбаатар: Д.Ганбат гишүүнд 1 минутыг нэмж өгье.

Д.Ганбат: Тэр юу байна. Одоо хилийн цэрэг чинь Хууль зүйн яамны харьяа байх аа. Хилийн цэрэг, дотоодын цэрэг.

Бас нэг хүн амиа хорлолоо л гэж байна. Ийм юм гараад байх юм. Энэ дээр яаж хандаж байна, ямар хариуцлага тооцож байна вэ? Тайван цагт энэ чинь болохгүй шүү дээ.

Нөгөө талаар тэр Д.Мөнх-Эрдэнэ. Миний зөвлөх байсан. Ардчилсан намын бүлгийн даргын зөвлөх гээд явж байсан. Тэгээд эрүүдэн шүүгээд байна уу, ямар байна аа? Би ер нь нэг очъё гэж бодож байна.

Ер нь Хууль зүйн байнгын хорооны гишүүний хувьд ч гэсэн, Хүний эрхийн дэд хороонд ч гэсэн би байдаг л даа. Тэнд юу болоод байна вэ? Энд Шүүхийн шийдвэр биелүүлэх газрын дарга байгаа юм шиг байна. Хэзээ хэдийд

очиж газар дээр нь танилцаж болохоор байна?

Яг тэр сонин хэвлэл дээр байгаа.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Б.Энхбаяр сайд аа, жинхэнээсээ маш чухал асуулт асуулаа шүү.

Яагаад гэвэл өнөөдрийн бид нарын энэ яриад байгаа чинь дандаа эрх зүйн чадамжтай хүмүүсийн ялын тухай яриад байгаа юм.

Энд яах аргагүй сэтгэцийн болон сэтгэл зүйн асуудалтай хүмүүсийн энэ асуудал дээр чинь. Яагаад гэвэл адилхан гэмт хэргийг аль нь ч үйлдэж болзошгүй. Энэ дээр ер нь зохицуулалт юу байгаа вэ гэдгийг асуулаа. Энэ бол үнэхээр чухал юм хөндөж ярилаа шүү. Яригдахгүй байгаад байгаа. Ерөөсөө.

Б.Энхбаяр: Хүүхдийн эсрэг, ялангуяа бага насны хүүхдийн эсрэг үйлддэг гэмт хэрэгт оногдуулах ялын бодлого манайх сул улсад ордоггүй.

Одоо бидний өргөн барьсан төсөл хэрвээ дэмжигдэж Улсын Их Хурлаар батлагдвал хүүхэд, тэр дундаа бага насны хүүхдийн эсрэг үйлдэгдэж байгаа, бэлгийн эрх чөлөөний эсрэг үйлдэгдэж байгаа ялын бодлого манай Эрүүгийн хуульд байгаа ялын хамгийн дээд тулалт явагдана гэсэн үг.

Үүнээс цаашаа чангадах хязгаар байхгүй. Хамгийн дээд тал руу нь аваачиж байна гэсэн үг. Тухайлбал, одоо гэхэд бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт оногдуулж байгаа ял бол хүн алахаас хоёр дахин өндөр байгаа. Хүн алсан гэмт хэрэгтэнд ногдуулж байгаа ялаас бага насны хүүхдийг хүчиндсэн

гэмт хэрэгт оногдуулж байгаа ял хоёр дахин их байгаа.

Тэгэхээр бид ял шийтгэлийн хувьд бага тийм улс биш ээ.

Энэ дээр тантай санал нэг байна. Ганцхан энэ асуудалтай ялын бодлогоор тэмцэхгүй.

Тухайлбал, манай нам 2011 онд эдийн засгийг 17 хувийн өсөлттэйгөөр Ардчилсан намд хүлээлгэж өгч байсан байдаг юм. Тэр үед хүчирхийлэл, тэр дотроо танхай, хулгай, хүчирхийллийн хэргүүд хоёр дахин буурч байсан байдаг юм. Энд ял ямар ч чангалаагүй байсан үед шүү.

Өөрөөр хэлбэл хүмүүсийн амьжиргаа дээшлээд, бүгд хөдөлмөрлөөд, ар гэр тайван амгалан болоод ирэхээр гэмт хэрэг аяндаа буурдаг.

Тэгэхээр бид энэ бусад асуудлуудыг маш анхаарах ёстой гэдгийг би хэлье.

Тэр эрхгүй этгээд гэдгийг бид судалж үзсэн юм.

Өөрөөр хэлбэл жолооны эрхийн хасуулсан этгээдийг яах вэ гэдгийг бид судлаагүй биш судалсан юм. Тэгээд жоохон төвөгтэй байсан. Үүнийг шууд гэмт хэрэгт тооцчихъё гэхээр ер нь манай хөдөөгүүр жишээлбэл Баянхонгорынхон бол тэгээд л тэр чигээрээ л бараг жолооны үнэмлэхгүй л мотоцикл бариад л малаа маллаж байгаа. Бүгдийг нь гэмт хэрэгтэн болгох уу гэхээр та сонгогчгүй болчих гээд байсан юм.

Тэгээд энэ бол бас бодит амьдралаас үүдэлтэй асуудал байгаад байдаг. Зөвхөн хот суурин газарт жолооны эрхгүй этгээд тээврийн хэрэгсэл

жолоодож байгааг нь гэмт хэрэгт тооцчихъё гэхээр Монгол Улс нэгдмэл улс. Хөдөө нэг үйлчилдэг хууль, хотод нэг үйлчилдэг хууль гэж байж болохгүй байгаад байсан юм.

Тийм учраас энэ асуудлыг бид нэлээн судалгаатай тооцооллын үндсэн дээр цаашдаа ярья гэдэг утгаар түр хойш нь тавьсан шүү. Түр хойш нь тавьсан гэдгийг танд хэлье.

Д.Мөнх-Эрдэнийн тухайд Д.Ганбат дарга хоёулаа, би тантай цуг очъё. Би өөрөө тантай цуг очъё. Энэ асуудлыг газар дээр нь тантай цуг очиж өөрөө тодруулж үзье.

Энэ хэвлэл мэдээллээр яваад байгаа асуудал нь үнэн бодитой эсэх асуудлаар Шийдвэр гүйцэтгэх байгууллагын дарга хариулах нь зүйтэй байх гэж бодож байна.

Д.Цогтбаатар: 7 дугаар микрофон.

О.Амарсанаа: Амрыг эрье. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга О.Амарсанаа. Д.Ганбат гишүүний асуултад хариулъя.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Зүүнхараа дахь хорих 413 дугаар ангид Д.Мөнх-Эрдэнэ хоригдож байгаа.

Д.Мөнх-Эрдэнийн эрх, эрх чөлөөнд халдсан, амь нас, эрүүл мэндэд гэмтэл учруулсан аливаа халдлага асуудал болоогүй гэдгийг танд хариуцлагатайгаар мэдэгдье.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус гэнэтийн шалгалтуудыг харьяа нэгжүүддээ, ялангуяа хорих анги,

байгууллагуудад тодорхой давтамжтайгаар явуулдаг.

Энэ ажлын хүрээнд тухайн ангид гэнэтийн үзлэг, шалгалт хийгдсэн. Энэ үзлэг, шалгалтад хорих ял эдлүүлэх алба болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа тусгай нэгжийн алба хаагчид мөн оролцсон ийм арга хэмжээ болсон.

Энэ арга хэмжээний хүрээнд Д.Мөнх-Эрдэнэтэй холбоотой, түүний эрх, эрх чөлөөнд халдсан, гэмтэл учруулсан ямарваа нэгэн асуудал болоогүй гэдгийг хэлье. Хариулж дууслаа.

Д.Цогтбаатар: Тодруулъя.

Д.Ганбат: Мэдээж хэрэг Хууль зүйн сайдад талархаж байна.

Тэр газар дээр нь очиж үзье, харъя гэж байгаад.

Шүүхийн шийдвэр биелүүлэх газрын дарга ганц Д.Мөнх-Эрдэнэ биш ээ. Ер нь ямаршуухан байгаа вэ?

Нөгөө талаар ямар нэгэн зодож нүдэж, гэмтээсэн ийм зүйл байхгүй л гэж л байна. Тэрийг ойлголоо, харлаа, ярилаа.

Үүнээс гадна бас тэгэхгүйгээр сэтгэл санаа болон янз бүрийн дарамт үзүүлж болдог. Би чинь бас цэргийн алба хаасан хүн шүү дээ. Мэднэ. Цэрэгт байсан. Тийм. Яаж дэглэдэг вэ, яадаг вэ гэдгийг мэднэ. Тийм. 20, 30 жилийн өмнө тийм байсан.

Мэдээж хэрэг танайд гайгүй л байх л даа. Тэр сэтгэл санааны хувьд дарамталж явган цуваа юу билээ, галуун цуваа гэдэг юм. Тийм. Алхана. Тэгээд янз янзын юм байдаг л даа.

Тиймэрхүү маягаар хүнийг эрүүдэн шүүх ийм зүйл байна уу? Байхгүй юу?

Д.Цогтбаатар: 7 дугаар микрофон.

О.Амарсанаа: Хорих анги байгууллагууд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу, дотоод цагийн хуваарийнхаа дагуу өдөр тутмын үйл ажиллагаа явуулж байгаа.

Төв, орон нутагт прокурорын байгууллага, хүний эрхийн байгууллагууд манай байгууллагатай хамтраад байнгын хяналт тавьж хамтран ажиллаж байгаа.

Хүний эрх, эрх чөлөө хэрхэн хангагдаж байна вэ гэдэг дээр байнгын хяналт тавьж ажиллаж байгаа. Ямарваа нэгэн байдлаар эрүүдэн шүүсэн, бусад хэлбэрээр дэглэсэн янз бүрийн асуудал байхгүй гэдгийг танд хариуцлагатайгаар хэлье.

Холбогдох хууль эрх зүйн үндэслэл журмынхаа дагуу үйл ажиллагаа явагдаж байгаа гэдгийг танилцуулъя.

Д.Цогтбаатар: Яг энэ асуудалтай холбогдуулаад нээрээ нэг ийм юм хэлчихмээр байна.

Байнгын хороон даргын хувьд.

Д.Ганбат гишүүн, Б.Энхбаяр сайд та хоёр Байнгын хорооны гишүүдийн хувьд асуудалдаа очиж танилцаад, энэ талаарх олж мэдсэн мэдээллээ надад ирж тайлан тавиач ээ.

Байнгын хороо, ялангуяа хүний эрхийн асуудлаар цөөнхийг нь тавьж байгаа асуудалд онцгой анхааралтай хандах ёстой. Яагаад гэвэл хамгийн их эд нар дээр гомдол ирж, хамгийн их мэдэрч байж магадгүй.

Тэгэхээр хэрэв зөрчил гарч байгаа бол тэр болгон бас мэдэхгүй өнгөрөх эрсдэл байдаг учраас энэ асуудал дээр цөөнхийн үгийг сонсож байх ёстой.

Тэгээд эргэж ирж энэ дээр надаа энэ асуудлынхаа талаар тайланг тавиарай.

Байнгын хор хорооноос ийм үүрэг өгч байна. Байнгын хороон даргын хувьд.

Ингээд асуулт асуух гишүүд асуултаа асуулаа.

Би хоёр, гурван асуулт асуучихмаар байна. Сайдаас нэг асуулт асуумаар байна.

Энэ авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн хүмүүс, ялтнуудад тэр нөгөө ялын бодлого, ялангуяа энэ дээр ялтныг хугацаанаас нь өмнө суллах асуудал уг нь яригдаж байсан.

Тэгээд таны танилцуулгыг би өнгөрүүлчхэв үү. Энэ гарсангүй өнгөрчих шиг бодох юм. Уг нь энэ авлига, албан тушаалын хэрэг дээр ер нь ялыг цаашаа чангатгах бодлого цаашаа үргэлжлээд явах ёстой.

Өвөл яг энэ Байнгын хорооны зүгээс авлига, албан тушаалын хэргийг өршөөхгүй болгох тэр ажлын хэсэгт нь би өөрөө ороод энэ өршөөхгүй гэдэг асуудлыг оруулж байсан.

Одоо харин хугацаанаас нь өмнө суллахгүй гэдэг асуудал яригдаад байсан.

Энэ хаах нь явна вэ? Сайд энэ дээр нэг тайлбар өгмөөр байна.

Хоёр дахь асуудал нь, нэг ийм юм байна. Энэ бага насны хүүхдийг 16 наснаас гээд, 16 нас хүртэл гээд өөрчлөөд явахаар энд нэг ийм асуудлууд гараад байгаа юм.

Яг энэ гадаад харилцааны чиглэлийн хэд хэдэн асуудал Б.Энхбаяр сайд аа, амьдрал дээр гарна.

Тэгэхээр жишээлбэл Казахстанд миний санаж байгаагаар гэрлэх эрх, гэр бүл болох, гэрлэх эрх 16 наснаас нээгдэж байгаа.

Тэгэхээр энэ чинь юу гэсэн үг вэ гэхээр манай зөндөө иргэд тэнд хүнтэй гэрлэж болно. Тэгээд Монгол руу хүрээд ирдэг. Манайд нөгөөдөх нь бага насны хүүхэд гээд.

Энэ чинь зөвхөн бэлгийн хүчирхийллийн тухай асуудал биш, нэг гэр бүл болчихоор гэр бүлийн өмчийн асуудлууд гарч ирнэ.

Нөгөө хоёр чинь 16, 17 хүрээгүй байхдаа салах асуудал гараад ирвэл тэр гэрлэлт чинь өөрөө хүчин төгөлдөр байх уу. Өмч яаж хуваагдах вэ. Нөгөө хүн чинь өмчийн асуудлаар ямар нэгэн нэхэмжлэл гаргах эрх байх уу, үгүй юу гээд.

Энэ бол жижиг асуудал биш болж хувирна шүү. Тооныхоо хувьд ч ийм эрсдэл бий.

Америкийн Нэгдсэн Улсад олон монгол иргэд амьдарч байгаа. Америкийн Нэгдсэн Улс чинь яг энэ талаараа 50 төрлийн, 50 улсын хууль явж байгаа гэж та нар бодож болно.

Их Британиас уламжилсан эдний гэр бүлийн хууль аягүй олон штатад нь, мужид нь, Их Британиас уламжилсан хууль нь явж байгаа. Тэр нь юу вэ гэхээр бараг 14 наснаас гэрлэж болж байгаа шүү.

Тэгэхээр Америкт хэчнээн монгол иргэн амьдарч байгаа билээ. Гэр бүл болж болох билээ. Энэ чинь Монголд тэгээд тэр хүмүүс наашаа шилжиж ирээд амьдрах юм бол яаж амьдрал дээр нөлөөлөх вэ гэдэг ийм юмаа.

Бид даяаршсан дэлхийд л амьдарч байгаа юм чинь. Үүнийгээ үнэхээр яалт ч үгүй бодох хэрэгтэй болох байх.

Өнөөдрийн Монголын үйлчилж байгаа хуулиар, одоо Иргэний хуульд жишээлбэл энэ 16 дугаар зүйлд иргэний эрх зүйн бүрэн бус чадамжийн тухай асуудлыг нь зохицуулсан байгаа юм.

Тэгэхэд энд 14-өөс 18 насны хүүхдүүдтэй холбогдсон эрхийн асуудал гараад байгаа юм л даа. Тэгэнгүүт бид чинь үүнийг 16 нас хүрчхэнгүүт 14-өөс 16 нас хүртэлх хүүхдүүдийн хувьд жишээлбэл ээж, ааваас өөрийн данстай байх, тэр дансандаа мөнгө байршуулах, тэрийгээ өөрийн үзэмжээр зарцуулах эрх чинь 14 настай хүүхдүүдэд байхгүй болчхож байгаа байхгүй юу. Өнөөдөр байж байгаа эрх байхгүй юу.

Тэгэхээр бид нэг юмыг нь шийдэх гээд. Амьдрал чинь өөрөө маш олон баялаг учраас өөр зөндөө талынх нь юмнуудыг аваачаад хөндчихөж байгаа юм биш биз дээ.

Үүнийгээ бид бодож үзсэн үү гэдэг энэ асуудлыг бас тавимаар байна. Ийм хоёр асуулт байна.

Б.Энхбаяр сайдын микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Бид өнгөрсөн оны сүүлээр авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй эвлэршгүй байх тухай Монгол Улсын Ерөнхий сайд бодлогоо зарлаж авлигын гэмт хэргээр ял шийтгэгдсэн этгээд өршөөл үзүүлэхгүй тухай хуулийг баталсан.

Мөн улс төрд нөлөө бүхий этгээдүүдийн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэхгүй гэдэг хуулийг баталсан.

Улс төрд нөлөө бүхий этгээд хээл хахууль авах юм бол бүх насаар нь хорих ялтай болгосон. Бид албан тушаалын хэрэг дээр эвлэршихгүй байх хуулийн бодлогоо парламент зарласан.

Энэ хуультай хамт одоо шинээр бүх төрлийн аливаа авлига, албан тушаалын гэмт хэргээр ял шийтгэгдэж, хорих ял эд эдэлж байгаа этгээдүүдийг хугацаанаас нь өмнө суллахгүй гэдэг мөн хуулийн төслийг өргөн барьж байгаа.

Энэ бол Монгол Улсын Ерөнхий сайдын өөрийн улс төрийнх нь бодлого.

Авлига, албан тушаалтнуудын хэргүүдийн тухайтад өнгөрсөн 10 жилийн хугацаанд 63 хүн буюу түрүүн ярьсан 3879 наана нь судлагдсан хүмүүсийн 1.6 хувь нь хугацаанаас өмнө судлагдсан байдаг.

Сүүлийн 10 жил 63 хүн. Цаашдаа энэ хууль батлагдсан тохиолдолд энэ хугацаанаас өмнө судлах асуудал авлигын гэмт хэрэгтнүүдийн тухайд байхгүй болно.

Хөнгөн албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаад ял

шийтгэгдсэн нярав, нягтлангуудын асуудлыг жоохон энэрч авч үзэх, ялгамжтай авч үзэх бодлого байхгүй уу, үгүй юу гэдэг дээр бид бас судалж авч үзсэн.

Монгол Улсын Ерөнхий сайд хатуу байгаа.

Ерөөсөө авлигачдыг өршөөл үзүүлэхгүй, хугацаанаас нь өмнө суллахгүй. Энэ зарчим бол миний хатуу байр суурь гэдэг асуудлыг надад ч үүрэг өгөхдөө хэлсэн, Засгийн газрын хуралдаанд ч гэсэн энэ байр сууриа хатуу нотолж Улсын Их Хуралд өргөн барьсан байгаа гэдгийг танд хэлье.

Таны хөндсөн энэ хоёр дахь асуудал их чухал асуудал. Бид яг хүчиндэх гэмт хэргийн тухайтад 14, 16, 18 гэсэн насны ангилалтайгаар хуулийн төслийг өргөн барьсан байгаа.

Өөрөөр хэлбэл яг таны хөндөж буй энэ бага насны хүүхэд гэдэг насны ангилал улс орнуудад янз бүр байдаг.

Дэлхийн улс орнуудад хамгийн бага нь үүнийг 12 насаар тооцдог. Хамгийн өндөр нь 18 насаар тооцдог юм билээ. Тухайлбал, таны хэлсэнчлэн Америкийн штат болгон энэ насыг өөр өөрөөр тогтоодог юм билээ. Зарим муж нь 18 нас гээд бүр заачихсан мужууд ч байна.

Манай хөршүүдийн тухайд энэ насыг 13-аар тооцож авдаг. Жишээлбэл.

Тэгэхээр манай улсын эрх зүйн уламжлал үүнийг 14 гэж байсан. Хүчиндэх гэмт хэргийн тухайд яагаад ярьж байна вэ гэхээр энэ насны хүүхдүүд хоорондоо хайр сэтгэлийн үндсэн дээр бэлгийн харьцаанд орсон тохиолдолд хүчирхийлсэн хэв шинжийг бага насны

хүүхдээс дооших хэрэг дээр хүч хэрэглэсэн шинжийг авч үздэггүй.

Өөрөөр хэлбэл заавал хайр сэтгэлтэй, ингээд өөрсдөө бэлгийн харьцаанд орсон байхад тэр гэмт хэрэгтэн аль аль нь болдог хоёулаа.

Тийм учраас энэ насны асуудал маш чухал асуудал байдаг. Тэр ч утгаараа 14, 16, 18 гэсэн ийм насны ангилалтайгаар авч үздэг. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн тухайтад мөн 18 ба түүнээс дээш насны этгээд үйлдсэн тохиолдолд энэ хүчиндэх гэмт хэргийг авч үзэж.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Хугацааг нэмж өгье. Асуултын хариултыг гүйцэд авъя.

Б.Энхбаяр: Өөрөөр хэлбэл бид түрүүн хэлсэн. Би слайд дээрээ хэлсэн.

10 орчим бага насны хүүхдийг алах, 10 гэмт хэргийг би дурдаж хэлсэн.

Бэлгийн мөлжлөг, хулгайлах, бага насны хүүхдийг оролцуулж садар самууныг сурталчлах, бага насны хүүхдийг аюултай байдалд орхих, тусламж үзүүлэхгүй байх, санаатай хүндэтэр болон хөнгөн гэмтэл, хүнд гэмтэл учруулах гэсэн энэ 10 гэмт хэрэг дээр 16 болж байгаа юм.

Яг саяын тэр өөрсдийн хайр сэтгэл дээр учирч байгаа асуудал дээр 10.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Энэ асуудлыг бодоод тусгасан байж байгаа юм байна гэж би ойлголоо. Зөв үү?

Одоо ингээд гишүүд асуултаа асууж, хариултаа авч дууслаа. Энэ асуудлаар санал хэлэх гишүүд байна уу? Нэрсийг нь авъя.

Санал хэлэх гишүүд алга. Тэгвэл би нэг товчхон хураангуйлаад хэдэн зүйл хэлчихье гэж бодож байна.

Нэгдүгээрт, Б.Энхбаяр сайд шуурхай ажиллаад ийм тулгамдсан асуудлуудаар даруй хуулийн төсөл аваад орж ирж байгаа нь чухал байна.

Мэдээжийн хэрэг ингэж яаралтай орж ирж байгаа юмнуудад тал талаас хэлэлцэх асуудлууд гаралгүй яах вэ. Энэ дээр нийгмийн шинж чанартай нийгмийн үнэхээр захиалга болсон хурц олон асуудлууд орж ирж байгаа болохоор энэ дээр Их Хурал нухацтай авч үзэх ёстой гэж бодож байна.

Би Засгийн газрыг нэг зүйлийг анхаараасай гэж бодож байгаа. Энэ яаралтай горимоор орж ирсэн байгаа. Гэхдээ дэгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд яаралтай дэгээр хэлэлцэхийн хоёр, гурван шалгуур байгаа. Тэр нь юу гэхээр Ерөнхий сайдаас энэ дээр санал тавьсан байхын зэрэгцээ, энэ нь эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулсан хууль тогтоомж байх ёстой.

Өөрөөр хэлбэл яаралтай бол бүх утгаараа яаралтай шинж чанартай байх ёстой гэсэн санааг 21.1 агуулсан байгаа юм. Тэгтэл манай энэ хууль маань хэрэгжих хугацаа нь 2024 оны 01 дүгээр сарын 01 гэж байгаа.

Тэгэхээр энэ чинь нөгөө яаралтай шинж чанараа өөрөө анхнаасаа тийм алдсан шинж чанартай санал орж ирж байна шүү гэдгийг бодолцож үзээрэй.

Өөр нэг зүйл нь энэ дээр харин мөрдөн байцаах, үүнд оролцсон хүмүүсийн нууцлалыг хадгалах тухай асуудлууд орж ирж байна. Үүнийг

үнэхээр тал талаас нь авч ярьж хэлэх ёстой.

Мэдээжийн хэрэг Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон хамгийн гол зүйл үгээ хэлэх эрх чөлөөний асуудал байгаа. Үүнийг юугаар ч, ямар ч халхавчаар, ямар ч зорилгоор хааж болохгүй.

Нөгөө талаас төрийн албыг хашаад явж байгаа хүмүүсийн энэ мөрдөн байцаалтын нууцаа хадгалах энэ үүргийн тухай асуудал байгаа. Энэ мөрдөн байцаалтын нууцыг хадгална гэдэг чинь хүний эрхийг хамгаалах гол механизмуудийн нэг.

Тэгэхээр энэ дээр энэ огтлолцлоо бодож онцгой анхаарч явж байх ёстой.

Зарим сэтгүүлчдийн зүгээс бүр ингээд өөрсдөө ярьж байна шүү дээ. Хэвлэл мэдээллийн эх сурвалжийг хумих гээд байна гэдэг чинь нөгөө мөрдөн байцаах байгууллагуудыг хэвлэл мэдээллийн эх сурвалж гээд олон нийтэд ингэж ойлгоод явж байгаа бол.

Би юу гэж хэлмээр байна гэхээр энэ мөрдөн байцаах байгууллага цагдаа, прокурор, холбогдох байгууллагууд энэ дээр гарч ирж бас мэдэгдэл, тайлбараа хийх ёстой шүү.

Энэ чинь бид эх сурвалж хэзээ ч байгаагүй биш юм гэдгийг. Өнөөдөр байгаа хуулиараа энэ биш шүү дээ. Тэгээд цаашдаа ч энэ биш байх болно.

Тэгэхээр энэ дээр энэ тусгай байгууллагууд тайлбар юмаа хэлнэ биз. Яагаад ингэж ойлгогдоод ингэж яриад явж байгаа юм.

Тэгээд энэ дээр бид цаашдаа энэ асуудлуудаа анхаарч явах ёстой. Тэгээд

хэлэлцүүлгийн дунд наанатай цаанатай асуудлуудаа яриад явах биз.

Ингээд санал хураалт руугаа оръё.

Тэгвэл ингээд энэ хуулийг хэлэлцье гэсэн томъёоллоор санал хураая. Гишүүд саналдаа оролцоно уу.

Ингээд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал 72.7 хувь байна.

Үүнийг хэлэлцүүлэхээр шийдлээ.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаарх хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Ингээд хуулийн төслүүдийг хэлэлцэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан танилцуулна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье.

Хуралдаан 1 цаг 43 минут үргэлжилж, 17 цаг 00 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД